

Б.Амгаланбаяр

ОЮУНЛАГ МЭДРЭМЖ ЦУВРАЛ

КОМПЬЮТЕРИЙН ГЭМТЭЛ ЗАСВАР

ХОЁРДУГААР ДЭВТЭР/



GaVaL.net

11010001100100100111000111011011010001010010011110
001111011101000001010001100100100010001110110110

БАМГАЛАНБАЯР

ОЮУНЛАГ МЭДРЭМЖ ЦУВРАЛ

КОМПЬЮТЕРИЙН ГЭМТЭЛ ЗАСВАР

/хоёрдугаар дэвтэр/



УЛААНБААТАР ХОТ

2012 ОН

Өмнөх үг

Хүн төрөлхтөн үүссэн цаг үеэс эхлэн аливаа зүйлийг хялбар хийх арга, техник, технологи боловсруулан түүнийгээ илүү боловсронгуй болгож амьдрал ахуйдаа хэрэглэсээр өнөөг хүргэсэн. Компьютер нь бидний амьдарч байгаа өнөөгийн нийгэмд болон цаашиг зайлшгүй хэрэгтэй хүн бүхний эзэмших ёстой боловсрол болон хөгжиж байна. Компьютерийг хэрэглэснээр хүмүүсийн ажлын цаг багасаж, эдийн засагт хэмнэлт гаргаж, мэдээллийг богино хугацаанд дамжуулан боловсруулах, өдөр тутмын хэрэгцээг хангах ажлын багаж болоод байгаа нь тодорхой харагдаж байна.

Энэхүү номонд зохиогч миний бие компьютерийн техник болон програм хангамжийн хамгийн өргөн хэрэглэгдэх ухагдахууныг маш энгийн хялбар байдлаар бичихийг хичээллээ.

Компьютерт ямар алдаа гарсан, яаж тэр алдааг засварлах, мөн компьютерийг хэрхэн зөв хэрэглэх, нэмэлт өөрчлөлт яаж хийх, шинэ компьютер хэрхэн угсарч програм суулгах, компьютерийн сүлжээг хэрхэн зохион байгуулах, вирус болон бусад хамгаалалт хийх зэрэг олон асуудлыг шийдвэрээд энэхүү ном танд тус болно.

Энэхүү номын бүх агуулгыг бүгдийг сайтар ойлгон, дадлага туршилт хийснээр таны компьютер эзэмших чадвар бүрэн цогц байдлаар сайжрах болно.

“Оюунлаг мэдрэмж” Компьютерийн номнуудын нэг болох “Компьютерийн гэмтэл засвар - 2” номыг өөрийнхөө ширээний ном болгон ашиглан интернэт хэрэглээг бүрэн эзэмшиж сурах танд црээдүйг өөрийн ажиллаж буй салбарт тэргүүлж явах гарамгай сайн амжилт үзүүлэхийг хүсэн ерөөе.

Зохиогч



Компьютерийн үндсэн ойлголт

Компьютер нь мэдээллийг хулээн авч ямар нэгэн програмын тусламжтайгаар түүнийг боловсруулж нр дунг гаргаж өгдөг төхөөрөмж юм. Өөрөөр хэлбэл мэдээлэл боловсруулах электрон механик төхөөрөмж юм. Мэдээлэл боловсруулна гэдэг нь баримт бичиг боловсруулах, тоо бодох, тооцоо хийж график байгуулах, зураг зурах, дууны болон видео мэдээллийг засварлан боловсруулах гэх мэт.


Ерньмэдээлэл технологи хөгжсөнэнэд компьютерийн тусламжтай бүх төрлийн ажил хөдөлмөрийг хөнгөвчилж, дун шинжилгээ, боловсруулалтыг сайн хийж байна. Компьютер нь хоёр хэсгээс бурдэнэ.

- Техник хангамж /hardware/
- Програм хангамж /software/

Ийнхүү компьютерийг бурдуулдэг электроник механик эд ангиудыг техник хангамж буюу **hardware** гэнэ.

Техник хангамжийг удирдан ажиллуулдаг системийг програм хангамж буюу **software** гэнэ.

Компьютерийн хүчин чадал, овор хэмжээ, хэрэглэх шаардлагаар нь хэд хэд ангилна. Жны: Персональ /Desktop/ Laptop /Notebook/, PDA, Tablet PC, Ultra-Mobile PC, Pocket PC, Workstation, Minicomputer, Mainframe, Supercomputer






Персональ /Desktop/ компьютер

Ширээний компьютер бөгөөд энгийн хэрэгцээнд ашиглана. Бидний өдөр тутам хэрэглэж байгаа процессор, дэлгэц, гар хулгана зэрэг үндсэн төхөөрөмжүүд, туслах төхөөрөмжүүд нь тусдаа бие даасан хэлбэртэй бөгөөд тэдгээр нь хоорондоо холбогдож персональ /desktop/ компьютерийг буруулна. Энэ компьютерийг Dell, Lenovo, Acer, LG, зэрэг компаниуд үйлдвэрлэдэг.

Мөн эдгээрийн дотоод эд ангиудыг үйлдвэрлэгч Intel, SIS, NVADIA, VIA, Samsung, ASUS гэх мэт маш олон компани байдаг. Эдгээр компаниуд нь өөр өөрийн гэсэн онцлогтой төхөөрөмжүүдийг хийх бөгөөд ерөнхийдөө нэг стандарттай хийдэг. Яагаад гэвэл эдгээр төхөөрөмжүүд нь хоорондоо холбогдож нэг цогц компьютер бий болгодог.



Мэдээлэл технологи хурдацтай хөгжиж байгаа болохоор бид ашиглаж байгаа аливаа тоног төхөөрөмж нь шин хялбар ашиглагдах, боловсронгуй болсоор байна.




Laptop /Notebook/ компьютер

Процессор, дэлгэц, гар, хулгана нь хамт байрлах бага оврын компьютерийг хэлнэ. Laptop буюу зөөврийн компьютерийг Notebook гэж нэрлэдэг бөгөөд тэжээлд залгахаас гадна батерейгаар ажиллах боломжтой овор хэмжээ багатай тул нэг газраас нэгийн рүү зөөж авч явахад тохиromжтой. Жишээ нь онгоц, номын сан, ажил дээрээ мөн уулзалтанг оролцож байх үедээ хэрэглэхэд тун тохиromжтой.

Зөөврийн компьютерийн ердийн жин нь 2.5 кг-аас ихгүй, зузаан нь 7.5 см батнуунээс чбага байдаг. Энэ компьютерийг IBM, NEC, Dell, Toshiba, Sony, Apple зэрэг компаниуд үйлдвэрлэдэг. Зөөврийн компьютерийг үйлдвэрлэхэд нарийн ажиллагаа шаардагддаг учир яг ашил үзүүлэлттэй desktop компьютерээс илүү үнэтэй байдаг.

Зөөврийн компьютерийг суурьний тусламжтайгаар ширээний компьютерийн том дэлгэцэнд залгаж хэрэглэдэг. Зөөврийн компьютер нь ердийн компьютераас хэмжээгээрээ бага тул дотоод сүлжээнд болон интернэтэд холбогдоход шаардагддаг modem, дотоод сүлжээний карт нь мөн жижиг байх шаардлагатай. Зөөврийн компьютерт зориулсан картыг PC Card буюу PCMCIA гэж нэрлэдэг. PCMCIA карт нь кредит картын хэмжээтэй агуул юм. Түүнчлэн CD-ROM, DVD-ROM, CD-WRITER, ZIP, Memory disk уншигч зэрэг төхөөрөмжүүд нь built-in буюу үйлдвэрээсээ суурьлагдсан байх бөгөөд солих, нэмж тавих боломжтой.






PDA, Plamtop, Pocket-PC, Handheld...

Гартаабариадавч явж болохуйцуг жижиг төхөөрөмжийг Palmtop компьютер ч гэж нэрлэдэг. Palm нь сүүлийн үеэд өргөн хэрэглэгдэж байгаа Personal Digital Assistant (PDA) буюу жижиг хэмжээний төон системийн төхөөрөмжийн нэр юм. 1996 онд анх удаа Palm Computing компани энэ төхөөрөмжийг имэйл шлгээх, тэмдэглэл бичих, тоглоом тоглоход зориулж Palm Pilot гэсэн нэртэйгээр гаргажээ. Уг төхөөрөмж нь шингэн кристалын дэлгэц буюу LCD дэлгэцтэй бөгөөд хийж буй үйлслийг нь үүн дээр гардаг. Энэ төхөөрөмжид гар (keyboard) байдаггүй бөгөөд ямар нэг үйлдэл хийх, үсэг, үг, тоо зэрэг тэмдэгтүүдийг бичих тохиолдолд үзэг шиг хэлбэртэй жижиг дохиурыг ашигладаг. Үүнийг grafitti гэх бөгөөд үүний тусламжтайгаар бичих гэж буй үсэгтомуу эсвэл тоон дээр дараахад гардаг.

Palm дээр зөвхөн өгөглийг боловсруулж, хадгалааг зогсохгүй мөн desktop эсвэл laptop компьютераас файл татаж авч өөр дээрээ боловсруулаад дараа нь эргээд компьютер лүү хуулах боломжтой. Palmtop нь жижиг гар баригдах хэмжээтэй тул Handspring, Handheld, Pocket-PC, Tablet PC, Ultra-Mobile PC зэргээр нэрлэдэг бөгөөд хэлбэр дизайн нь янз бүр байдаг.




Mainframe, Workstation...компьютер

Эдгээр компьютерууд нь ердийн персональ /desktop/ компьютераас олон дахин том, хүчин чадал, хурд, багтаамж шилүү байдаг. Олон хэрэглэгч зэрэг хандах боломжтой. Ихэвчлэн internet server, эрдэм шинжилгээний хүрээлэн зэрэг том байгууллага хэрэглэнэ.



iMac / Macintosh/ компьютер

Энэ төрлийн компьютер нь хэрэглэгч ашиглахад хялбар хийгдсэн. Интернэт болон вэб хуудастай ажиллахад тохиromжтой програмтай. Анх 1977 онд Apple компани гаргасан. iMac-ын "i" усэг нь internet гэсэн угийг илэрхийлнэ.





Компьютерийн техник хангамж

Компьютерийн техник хангамж гэдэг нь бидний гаргарт баригдаж, нүдэнд харагдаж байгаа бодит биет тоног төхөөрөмжүүдийг хэлнэ. Эдгээр нь өөрийн гэсэн нэр, хүчин чадал, онцлог шинж чанартай байдаг бөгөөд өөрийн гэсэн гүйцэтгэх нүрэгтэй.

Техник хангамжийг өөр өөр компаниуд үйлдвэрлэдэг. Intel, Celeron, LG, Asus, Samsung, Acer, Award, IBM, Sony гэм мэт олон ынч компаниуд байдаг. Гэхдээ эдгээр компаниуд ерөнхийдөө нэг стандарттай үйлдвэрлэнэ.

Компьютерийн техник хангамжийг судлахад хялбар болгож яз бүрээр төрөлжүүлэн ангилдаг. Бид дараах байдлаар ангилан үзэж судалъя.

- ⦿ оролтын төхөөрөмж (удирдлагын хэсэг)
- ⦿ санах ой (дамжуулах хэсэг)
- ⦿ төв процессор (боловсруулах хэсэг)
- ⦿ эх хавтан, нэмэлт карт (бусад оролт гаралт)
- ⦿ гаралтын төхөөрөмж (мэдээлэх хэсэг)
- ⦿ хадгалах байгууламж
- ⦿ бусад гадааг төхөөрөмж

Гэсэн хэсгүүндэд хуваагдана.

Компьютер нь мэдээллийг оролтын төхөөрөмжийн тусламжтайгаар гаднаас оруулж тоон хэлбэрт шилжүүлэн санах ойгоор дамжин төв процессороор боловсруулагдан хадгалах төхөөрөмжиуд хадгалах эсвэл гаралтын төхөөрөмж болох дэлгэцэнд гарах, принтерээр хэвлэгдэх зэрэг үйлдэл гүйцэтгэгдэнэ. Эдгээр үйлслийг удирдах төхөөрөмж удирдана. Ерөнхий ажиллах зарчим нь ийм дамжлагатай.



Оролтын ба удирдлагын төхөөрөмжүүд

Мэдээллийг компьютерт ямар нэг хэлбэрээр оруулах, хөрвүүлэх, удирдах уургийг гүйцэтгэнэ. Гаднаас оруулж байгаа мэдээлэл нь янз бүрийн хэлбэртэй байх бөгөөд оролтын төхөөрөмжүүд нь эдгээрийг ямар нэг байдлаар хөрвүүлэн компьютер ойлгох түвшинг хүргэнэ. Оролтын төхөөрөмжүүд

Keyboard - гар

зэрэг нь оролтын

Mouse - хулгана

төхөөрөмжүүд болно.

Scanner - скайнер

Эдгээрийг дэлгэрэнгүй

Microphone - микрофон

авч үзье.

Digital camera - дижитал камер

Гар-Keyboard

Гар нь компьютерийг удирдах, компьютерт /усэг, тоо, тэмдэг/ тэмдэгт оруулах уурэг гүйцэтгэнэ. Өөрөөр хэлбэл текстийг компьютерт бичиж оруулна. Стандарт гар 101-108 товчлууртай бөгөөд үндсэн, функциональ, тоон, хос горимын гэж хуваана.



Гар нь процессортой залгагдах оролтын хэлбэр нь одоогийн байдлаар DIN port, PS/2 port, USB port, Wireless гэсэн 4-н янз байна.

Сүүлийн veg USB порт эсвэл Wireless гар их хэрэглэж байгаа. Wireless гар гэдэг нь утасгүй бөгөөд тусгай антен ашиглан долгиноор мэдээлэл дамжуулдаг.



Түгээмэл хэрэглэгдэг товчлууруудын үүрэг:

Esc - командыг нийтгэнэ. /гараах, буцах, хүчингүй болгох/

Tab - курсорын байрлалыг тодорхой зайд шилжүүлэх.

Caps Lock - всэг тогтмол томоор бичигдэнэ.

Shift - товчны хамт дараахад тэмдэгт шилжүүлэх үүрэгтэй

Ctrl ба Alt- товчнуустай хамт дарагдаж команд билгүүлнэ.

Space- уг хооронд сул зайд авна.

Backspace - курсор байрласнаас өмнөх тэмдэгтийг устгана.

F1-F12 - функциональ товчлуурууд

Enter - командыг зөвшөөрөх, дараагийн мөрд шилжүүлэх

Delete - тэмдэглэсэн мэдээллийг устгах

Home - курсорыг мөрийн эхэнд шилжүүлэх

End - курсорыг мөрийн төгсгөлд шилжүүлэх

Page Up - нэг хуудас урагш шилжүүлнэ.

Page Down - нэг хуудас доош шилжүүлнэ.

Print Screen - дэлгэц дэх цонхыг санаах ойд хуулах /сору/

Pause Break - хийж байгаа үйлдлийг түр зогсоох

Num Lock - дарагдсанаар тоон товчлуурыг идэвхжүүлнэ.




Бид компьютер дээр текстийг хурданбичихийн тулд 10-н хурууний байрлалыг зөв сонгох хэрэгтэй. Мөн компьютерийн гар дээрх всгийн байрлалыг цээжлэх шаардлагатай. Тиймээс та 10-н хуруугаар бичих дасгал програмыг сайтар хичээнгүй хийх хэрэгтэй. Монгол всгийн байрлал дээрх хэлбэртэй.



Хулгана-Mouse

Хулгана нь хэрэглэгч компьютерийг удирдах болон сонголт хийх зэрэгт хэрэглэгдэнэ. Хулганыг хөдөлгөхөд дэлгэцэн дээр гүйж байгаа сумыг курсор гэх бөгөөд компьютер ямар чадалттай хийж байгаагаас хамаарч хэлбэр нь өөрчлөгдөж байдаг. Хулгана нь **механик** мэдрэгчтэй байснаа **оптик** мэдрэгчтэй болсон. Хулгана нь ерөнхийдөө хоёр товчтуур нэг гүйлгэгчээс бүрдэнэ. Эдгээр нь өөр өөрийн гэсэн нэрэгтэй. Процессортой залгагдах хэлбэр нь одоогийн байдлаар **Serial port**, **PS/2 port**, **USB port**, **Wireless** гэсэн 4-н янз байна. Сүүлийн USB порт эсвэл Wireless гар их хэрэглэж байгаа. Wireless гар гэдэг нь утасгүй бөгөөд тусгай антен ашиглан долгиноор мэдээлэл дамжуулдаг.



Microphone-Микрофон


Дуу авиааг компьютерт оруулах нэрэгтэй бөгөөд компьютерт Soundcard төхөөрөмжийн тусламжтай ажиллана. Бие даасан хэлбэртэйгээс гадна чихэвчтэй хамт байдаг. Микрофон ашиглан утсаар ярих, интерактив хичээл вээхэд зориулагдсан. Голдуу дангаараа бус чихэвчний хамт байдаг ба энгийн микрофонтой ашиглан.





Скайнер-Scanner

Цаасан дээр байгаа бэлэн мэдээллийг компьютерт оруулахад ашиглана. Өөрөөр хэлбэл фото зураг, текст зэрэг цаас дээр байгаа зурган мэдээллийг уншаад түүнийгээ тоон хэлбэрт шилжүүлж тусгай програмын тусламжтайгаар компьютерт оруулж зурган файл болгон хадгалах нүрэгтэй.




Скайнерийнхүчин чадлыг текст болон зургуүйг хэдэн dpi буюу нягтралтайгаар татаж байна гэдгээс хамааран тодорхойлдог. Скайнерийн өнго ялгаруулалт ихэвчлэн 72-1200 dpi байдаг. DPI гэдэг нь dot per inch гэсэн угнуудийн товчлол бөгөөд утгачилан орчуулбал нэг инчэд багтах цэгийн

олонлог юм. Мөн Bit depth буюу битийн нягтралаар илэрхийлнэ. 8bit color - 256өнгө 16bit color 65536өнгө гэх мэт. Харин Color depth гэдэг нь тухайн зураг хичнээн өнгөөр ялгарч харагдахыг заасан нэвтрэлт юм.

Скайнерийг компьютерт LPT port, COM port, USB port зэргийн тусламжтайгаар холбогдог.

barcode scanner гэж байх бөгөөд түүнийг худалдааүйлчилгээний байгууллага өргөн хэрэглэдэг.





Скайнер дагалдаж ирдэг **driver**, **scanmaker** програмаас гадна PhotoShop, Adobe Photo Deluxe гэх мэт зургийн програмуудаас скайнердах чадвэл хийх боломжтой.

Color: Энэ нь хөрвүүлэх гэж буй зургаа ямар өнгөөр хөрвүүлэх вэ гэдгийг сонгох сонголт юм. Grayscale - хар саарал, Color - өнгөт гэх мэт сонголтууд байдаг.

Resolution: 72, 96, 300, 600, 1200 гэх мэт. Та эндээс тухайн хөрвүүлэх гэж байгаа зургаа ямар зорилгоор ашиглахаас хамаарч сонголтоо хийх хэрэгтэй. Зургаа хэвлэх гэж байгаа бол 300 dpi гэсэн сонголтыг хийхэд хангалттай.

Preview: Энэ нь хөрвүүлэх зургаа урьдчилан харах хэрэгсэл юм. Ингэс урьдчилан харснаар тухайн зургаа бүтнээр нь аль эсвэл тодорхой хэсгийг нь л хөрвүүлэх гэх зэргээр сонголт хийх боломжтой болно.

Scale: Энэ нь тухайн зургыг өөрийнх бодит хэмжээгээр эсвэл тодорхой хувцас үзүүлэхэд тухайн зураг таны ашиглаж байгаа програмын /жишээнь PhotoShop/ажлын талбарт орж ирнэ. Үүний дараа зургандаа нэр өгч хадгалах хэрэгтэй.


Хавтгай тавцант скайнер буюу Flatbeds нь фото болон бусад зургуудыг хөрвүүлж болохоос гадна зарим нэг нь фото зургын негатив хальс, слайд зэргийг хөрвүүлэх боломжтой байдаг. Энэ тохиодолг transparency adaptor буюу негатив хальс болон слайдыг байрлуулах нэмэлт хэрэгсэлтэй байдаг.

Оптик скайнер нь текст бичвэрийг зурагнаас ялгаж чаддаггүй түүнийг зураг мэтээр хүлээн авч оруулдаг. Харин та скайнераар хөрвүүлэгдэн орж ирсэн эдгээр бичвэрүүдийг засварлах шаардлага гарвал оптик дурслэлийн таних систем буюу Character recognition system (OCR) -ийг хэрэглэх хэрэгтэй. Ингэснээр зургийг ASCII код болгон хувиргадаг. OCR програмуудаас өргөн хэрэглэдэг нь FineReader юм.



Digital camera

Дурсийг бичих, дурсийг фото зураг болгож компьютерт оруулах Digital camera буюу тоон зургийн аппарат нь ердийн зургийн аппараттай агуул зураг авах ширэгтэй боловч ажиллах зарчим, зургийн чанар, аппаратын бүтэц зэрэг олон зүйлээр хоорондоо ялгаатай.



Тоон зургийн аппаратанд хальс хэрэглэдэггүй бөгөөд зураг дараваг **CCD** буюу **charged couple device** төхөөрөмж нь гол ширэг гүйцэтгэн зургийг боловсруулж **buffer** луу илгээнэ. Зураг buffer-г очсоны дараа компресс хийгдэн **JPEG** формат руу хувиргана. Улмаар боловсруулагдсан бэлэн зураг маань аппаратын санах ойн карт руу шлгээгдэнэ. Аппарат болгон санах ойн карттай ба **memory card** гэж нэрлэнэ. Зарим тоон зургийн аппаратнаас зургийг ямар нэг дискээр гаргаж авдаг бол зарим аппаратнаас тусгай зориулалтын кабелын тусламжтайгаар компьютерт залган хатуу диск рүү хуулна.

Дижитал камерын хувьд хүчин чадлыг нь зураг дурслэх цэгийн нягтралаар нь тодорхойлно. Ердийн болон өнгөт принтерт зургийг 10x15 см-ын стандарт форматаар хэвлэхийн тулд тоон зургийн аппарат нь 1300x1000 цэг, харин A4-ийн формат дээрх нь ердийн зургийн аппараттай дүйцэхүйц чанартай 1900x1200 цэг буюу 2,3 мегапиксель байх юм. Дижитал камерыг дурангийн татах чадварыг **zoom**, зураг дурслэх нягтралыг **megapixel**, хөдөлгөөн хийхэд дурсийн чанар хэрхэн өөрчлөгдхийг хурд хэмжинэ.


Мэргэжлийн болон сонирхогчдын дижитал камер гэж байх ба цаашдаа ч эрчимтэй нэмэгдэнүүлдэврлэгдэж байна.



Digital video camera

Дурс бичлэгийг бичихдээ мөн л CCD төхөөрөмжийн тусламжтай боловсруулан AVI форматтай болгож хувиргах бөгөөд санах ойн картруу видео файл болгон хадгална. Эсвэл видео хальсны тусламжтайгаар бичлэгээ хадгалдаг.

- Бүрэн дижитал - memory card, hard, CD дээр бичих
- Хагас дижитал - хальсанг бичих



-Бүрэн дижиталаар хийгдэж байгаа бичлэг нь шууд видео файл болон хувирдаг. Нягтралаа тохицуулж болдог.

-Хальсанг бичих SP mode, LP mode гэсэн 2 хэлбэртэй. SP mode нь нягтрал сайтай цөөн минут бичнэ. Харин LP mode нь нягтрал муутай их минут бичнэ.


Бичлэгийг компьютерт оруулах

Бүрэн дижитал нь шууд бичлэгээ компьютерийн видео файл болгож байгаа болохоор компьютерт шууд хуулж хэрэглэнэ. Харин хальсан дээр бичсэн бичлэгийг компьютерт оруулахдаа USB, 1394 зэрэг портоор тусгай залгуур утас, програм ашиглан хөрвүүлтэн оруулна. Эсвэл Video Card - ний тусламжтайгаар оруулна.



Web camera

Интернэт ашиглан дурс дамжуулахад зориулагдсан камер бөгөөд USB портоор компьютерт шууд холбогдох Yahoo, MNS, Skype зэрэг messenger програм ашиглан дурс дамжуулна. Интернэтээр дурс дамжуулах учир нягтрал мутай байдаг.



WebCamera Plus
PC Driver





Memory буюу Санах ой

Санах ой нь компьютерийн өгөгдлийг төв процессорт богино хугацаанд хүргэх, командыг түргэн гүйцэтгэх үүрэг бүхий микросхем юм.

Компьютерийг асаалттай байх үед хэрэглэгдэж байгаа бүхий л мэдээлэл өгөгдөл нь энд түр хадгалагдана.

Мэдээлэлийг хадгалах гэж хадгалж байгаа биш, боловсруулалт (өгөгдлийг нэмэж хасаж, хувиргах гм) хийх зорилгоор түр хадгалж байгаа нь энэ бөгөөд, үүний тулд өндөр хурдтай, CPU-нд ойрхон (учир нь CPU ихэнх цагаа RAM-д байгаа мэдээлэлд боловсруулалт хийхэд зарцуулна) хадгалах байгууламж шаардлагатай бөгөөд RAM нь энэ зорилгоор ашиглагдана.

Энэ нь компьютерийн хурд, хүчин чадлыг тодорхойлох бас нэгэн чухал үзүүлэлт болдог. Санах ойг хялбараар мэдээлэл дамжуулагч, хадгалагч мэтээр ойлгож болно. Санах ой нь хэд хэдэн төрөлтэй байдаг

1. шуурхай санах ой - RAM (Random Access Memory)
 - RAM төрөлүүд (EDO, ECC, SDRAM, DDRAM...)
 - RAM модулууд (SIMM, DIMM...)
2. тогтмол санах ой - ROM (Read Only Memory)
3. бусад төрлийн санах ой...

Ер нь бол санах ой гэдгээр RAM /шуурхай санах ойг/ ойлгож түүнийг ашиглаж байгаа. Бидний flash, memory card, hard, CD зэрэг нь нэг талаасаа хадгалах байгууламж, нөгөө талаасаа санах ой нэгэн төрөл юм.



Шуурхай санах ой – RAM Random Access Memory

Компьютер ажиллаж байх үед мэдээллийг хаана хадгалах эсвэл хааш нь шилжүүлэх зэргийг RAM буюу шуурхай санах ой зохицуулж байдаг.

RAM нь процессороос өгсөн командын дагуу өгөгдлийг хурдан хугацаанд бүх төрлийн диск төхөөрөмжрүү бичих эсвэл эдгээрээс буцааж уншдаг. Гэхдээ эдгээр уншсан мэдээлэл нь зөвхөн таны компьютерийг асаалттай байх хугацаанд л хадгалагдаж байх ба унтраасан тохиолдолд мэдээллээ бүрэн алдгар байна. Компьютерийг асаахад үйлдлийн системийг санах ойд ачаалдаг.

Компьютераар хийгдэж байгаа бүх үйлфэл санах ойгоор дамжина. Өөрөөр хэлбэл ямар нэг програмаар мэдээлэл боловсруулааг цаасан дээр буулгах, диск дээр хадгалах хүртэл санах ойд хадгалагдаж байгаа юм.

Энэ нь ямар нэг баримт бичгийг боловсруулж байхад (диск дээр хадгалаагүй) тэжээл тасрах тохиолдолд тэр мэдээлэл компьютер дээрээс арчигдана гэсэн үг.


Сүүлийн үеийн ихэнх RAM-нууд нь SIMM эсвэл DIMM модулынх байна.

SIMM (Single Inline Memory Modules) - ийм төрлийн модуль нь анх 8 битийнх гэж байсан (нэг ээлжиндээ зэрэг 8 бит мэдээлэл дамжуулна гэсэн үг). 1 MB, 2 MB, 4 MB багтаамжтай, 30 ріп-тэй байжээ.

DIMM - Одоо үед хамгийн оргөнөөр хэрэглэгдэж байгаа RAM-ны төрөл бол 64 битийн, SDRAM бөгөөд DIMM (Dual Inline Memory Module) гэж нэрлэнэ. 168 ріп-тэй DIMM сараах байдалтай байна. Сүүлийн үеийн процессорууд 64 битийн байдаг тул, та нэг удааг нэг модуль зоогоод хэрэглэх боломжтой гэсэн үг бөгөөд, DIMM RAM-нууд нь 2, 8, 16, 32, 64, 128, 256 MB хэмжээтэй,



RAM-г хадгалагдаж байгаа эдгээр мэдээллийг хэт цхэссэн өөрөөр хэлбэл түүний багтаамжаас хэтэрсэн тохиолдолг хатуу дискэн дээр бичилт хийдэг ба үүнийг virtual memory гэнэ. RAM нь цаг хугацааны хувьд шинэчлэгдэн сайжирсаар байна. RAM нь хэд хэдэн төрөл байдаг.




Эдгээрээс 168 pin, 168 pin PC100 гэсэн хоёр төрлийг PentiumII, PentiumIII компьютерт ашиглаж байсан. Харин бусдыг нь анхны дээр чөнгөнкомпьютерууд ашиглаж байсан.




184 pin CRIMM Spacer




184 pin 16bit RDRAM



232 pin 32bit RDRAM




326 pin 64bit RDRAM



64 bit RDIMM



XDIMM




XDR

Эдгээрдийг RAMBUS гэж нэрлэх бөгөөд тийм их түгээмэл ашиглагдахгүй. Ерөнхийдөө Pentium 4 болон тусгай зориулахад хамгийн шинжилгээний төрөл болдог.




Double Data Rate - DDR




184 pin DDR



240 pin DDR2



240 pin DDR2 FB-DIMM



240 pin DDR3

Бидний өргөн хэрэглэдэг RAM

DDRAM энэ төрлийн RAM нь PentiumIV ашиглагадаг. 184 PIN / хөлтэй/. Хэмжээний хувьсг доог тал нь 128MB дээд тал нь 512MB байдаг.

DDRAM-II энэ төрлийн RAM нь PentiumIV, PentiumD, IntelCore ашиглагадаг. 240PIN /хөлтэй/ Хэмжээний хувьсг доог тал нь 256MB дээд тал нь 2GB байдаг.

DDRAM-III энэ төрлийн RAM нь сүүлийн үеийн IntelCore ашиглагадаг. 240PIN /хөлтэй/ Хэмжээний хувьсг доог тал нь 512MB дээд тал нь 8GB байдаг.



RAM /notebook, laptop/



74 pin SO-DIMM



144 pin SO-DIMM



160 pin RDRAM RamBus SO-RIMM




200 pin DDR SO-RIMM



200 pin DDR2 SO-RIMM



204 pin DDR3 SO-RIMM



144 pin MICRODIMM PC100/133



172 pin MICRODIMM DDR/DDR2



214 pin MICRODIMM DDR2



FSB /Front Side Bus/

FSB /Front Side Bus/ гэдэг нь шуурхай санах ойн хурд гэж ойлгож болно. Энэ нь MHz нэгжээр хэмжигдэнэ. Санах ойн FSB нь их бага байх нь чухал биш харин CPU -ний FSB -тэй ашиглаж байх шаардлагатай. Хэрэв өөр бол Mainboard зохицуулан ажиллуулах боломжтой байдаг.

Mainbaord RAM CPU хоёрын FSB -ийг зохицуулах боломжгүй бол компьютерийн чадлыг ажиллагаа доголдох нөлөөтэй. Сүүлийн чадлын RAM нь PC2100, PC3200 гэх мэтээр FSB нь илэрхийлэгдэж байгаа. Энэ нь PC2100 = 2.1 Gbps, PC2700 = 2.7 Gbps гэсэн тутамд юм,

DDR2 ба DDR3 үзүүлэлтийн харьцуулсан байдал

	DDR2 SDRAM	DDR3 SDRAM
Clock frequency	200/256/333/400MHz	533/667/800MHz+
Effective Clock Speed	DDR2-400/533/667/800	DDR3-1066/1333/1600+
Theoretical Bandwidth	PC2-3200/4200/5300/6400	PC3-6600/10600/12800+
Discrete Density	256Mb, 512Mb, 1Gb, 2Gb	512Mb, 1Gb, 2Gb, 4Gb, 8Gb
Module Density	128MB-2GB, 4GB	256MB-4GB, 8GB, 16GB
Supply voltage	1.8V	1.5V
iCAS latency (CL)	3, 4, 5, 6 clock	5, 6, 7, 8, 9, 10 clock
Prefetch Buffer	4-bits	8-bits
Burst length	4, 8	4 (Burst chop), 8
On Die Termination	Yes	Yes (Dynamic OT)
Data Strobe	Single ended / Differential	Differential Default
Master Reset	No	Yes



Тогтмол санах ой – ROM Read Only Memory

Тогтмол санах ой руу өгөгдлийг бичих боломжгүй зөвхөн уншдаг бөгөөд компьютерийг асаахад ажиллуулдаг boot програм хадгалагддаг. Түүний RAM-аас ялгагдах гол онцлог нь компьютерийг унтраасан байхад ч өөр дээрх мэдээллээ алдалгүй хадгалсаар байдагт оршино. Учир нь тогтмол санах ойг таны компьютер дотор байрлах батарей зай тэжээж байдаг.

Тогтмол санах ойны бусад төрлүүд:

PROM: (Programmable read-only memory) Энэ төрлийн санах ойг програмыг хадгалж болох бөгөөд хэрвээ PROM нь ашиглагдаж байвал энэ програмыг устгаж цэвэрлэх боломжгүй зөвхөн өөр тийшээ зөөж хадгалах боломжтой.

EPROM: (Erasable programmable read-only memory) PROM-н нэг төрөл бөгөөд програмыг бичиж мөн устгаж болдог. Хэт ягаан түяаны тусламжтайгаар програмыг устгадаг.

EEPROM: (Electrically erasable programmable read-only memory) Мөн PROM-н нэг төрөл бөгөөд цахилгаан цэнэгийн тусламжтайгаар мэдээллийг нь устгах, дахин програмчилж болох нэгэн төрлийн тогтмол санах ой юм.

Програмчлахын тулд motherboard-с сугалах шаардлага байдаггүй. Учир нь компьютерт хэрэглэгддэг ердийн хувцас түүнийг програмчлахад хангалттай байдаг. Энэ төрлийн санах ойн хамгийн энгийн жишээ бол BIOS-ын микросхем юм.

Бусад санах ой:

Бүх төрлийн хадгалах байгууламжууд бусад төрлийн санах ойг хамрагдана. Өөрөөр хэлбэл диск төхөөрөмжүүд нь мэдээлэл хадгалах, дамжуулах үүрэг гүйцэтгэнэ. Эдгээрийг санах ой гэхээсээ шинүү удаан хугацаагаар тогтмол хадгалах байгууламж юм.



CPU буюу Төв удирдах байгууламж Central Processing Unit

Компьютер болгонд CPU chip буюу микропроцессор байдаг. Тэр нь мэдрэллийг боловсруулж үр дунг гаргадаг компьютерийн хамгийн гол төхөөрөмж буюу тархи нь юм. Микропроцессорыгүйгүй вийлдвэрлэдэг Intel, AMD, Celeron зэрэг фирмүүд байдаг.

Intel фирм нь: 8086, 286..., 586, PentiumI, II, III, IV, PentiumD, Intel Core, i3, i5, i7 төрлийн чипүүдийг /CPU/ гаргасан.


Celeron фирм нь: Celeron433, Celeron900, ..., Celeron2.8, CeleronD төрлийн чипүүдийг /CPU/ гаргасан

AMD фирм нь: Сүүлийн veg AMD Duron, Athlon, Sempron, Turion зэрэг нэргэйгээр чипүүдийг /CPU/ гаргасан

Эдгээр компани CPU нь хоорондоо ерөнхийдөө төстэй ба мэдрэлэл боловсруулах хурдаараа ижил байдаг. Мэдрэлэл боловсруулах хурдыг MHz нэгжээр хэмжих ба энэ хурд нь их нэмэгдсээр байна. $1024 \text{ MHz} = 1 \text{ GHz}$ нэгжтэй тэнцив. Жишээ нь: Intel фирмийн хамгийн анхны вийлдвэрлэсэн Intel 8088 процессорын хурд нь 4-8 MHz байсан бол хамгийн сүүлийн гаргасан Intel Core процессорын хурд маш өндөр болсон.

CPU -ний хувилбар нэмэгдэх тутамд процессорын хурд шилүү болж, ингэснээр вийлдлийг богино хугацаанд гүйцэтгэнэ.

Микропроцессор нь цаг хугацаа өнгөрөх тутам шинэчлэгдэж улам боловсронгуй болсоор байна. Манай улсад Intel фирмийн CPU хамгийн өргөн хэрэглэгдэж байна. Тухайн компьютерийг CPU-ны нэрээр нь нэрлэдэг.





Intel фирмийн CPU дараах хүчин чадалтай байна.

Intel PentiumIII	500mhz - 1.3ghz хуртэл хурдтай
Intel PentiumIV, D	1.4ghz - 3.0ghz хуртэл хурдтай
Intel Pentium Core	1.8ghz - 3.0ghz хуртэл хурдтай
Intel Core i3, i5,i7	1.2ghz - 3.33ghz... хурдтай

Хурдны хувьд байнга шинэчилэгдэж байдаг. Тиймээс тодорхой бичих боломжгүй. Зөвхөн ном бичих үеийн л хурдны үзүүлэлт гэгтийг анхаараарай.

Cache memory: Тусгай өндөр хурдны санах оин муж бөгөөд CPU нь хурдан хандах боломжийг бий болгоно. Энэ нь микропроцессор дотор эсвэл эх хавтангийн аль нэг хэсэгт байрласан байна. Cache memory нь CPU-г илүү хурдтай болгодог. Учир нь CPU-ийн байнт а хэрэглэгддэг гол instruction-нууд cache memory-г хадгалагддаг тул анх асаахаг instruction-ийг ачаалахад цаг зарцуулдаг илүү нийлмэл програмын хувьд cache memory-ийн ашиг тусыг мэдрэх болно.

CPU төрөл	cache memory
PentiumIV	512kb - 2mb
PentiumD	1kb - 4mb
Intel Core, i3,i5,i7	4m - 16mb /L2, L3 cache memory/

FSB /Front Side Bus/ гэдэг нь CPU -ний дотоод хурд гэж ойлгож болно. Энэ нь mhz нэгжээр хэмжигдэнэ. CPU FSB нийтийн бага байх нь чухал биш харин RAM -ний FSB -тэй агуул байх шаардлагатай. Хэрэв өөр бол Mainboard зохицуулан ажиллуулах боломжтой байдаг.

CPU төрөл	FSB
PentiumIII	66mhz, 100mhz 133mhz
PentiumIV,D	400mhz, 533mhz, 800mhz ...
Intel Core	800mhz, 1066mhz, 1333mhz ...



Motherboard – Эх хавтан

Motherboard буюу эх хавтан нь компютерийн системийн гол элементүүдийг агуулдаг бөгөөд микропроцессор, санах ой, диск төхөөрөмж, оролт гаралтын төхөөрөмж зэргийг хооронд нь холбож өгдөг чухал төхөөрөмж бөгөөд эдгээр нэрийн хувьтой нь холбогдуулж байгаа. Эх төхөөрөмжүүдийн үйл ажиллагааг зохицуулан байдаг. Эх хавтанг Motherboard гэж нэрлэхээс тагна Mainboard гэж нэрлэдэг. Motherboard буюу эх хавтанг ямар CPU суурилах боломжтойгоос хамааран дараах байдлаар ангилана.

- Socket PGA370 - Pentium3, Celeron CPU суурилах
- Socket 478 - Pentium 4, түүнтэй ашиг Celeron CPU суурилах
- Socket 437 - Atom CPU суурилах /CPU нь сууринласан/
- Socket 771 - Xeon CPU суурилах /server зориулалттай/
- Socket LGA775 - Dual Core, Core 2, CPU суурилах
- Socket 1156 - Core i5, Core i7 CPU суурилах
- Socket 1366 - Core i7, Xeon CPU суурилах
- Socket AMD - AMD CPU суурилах

Бид энгийн хэрэгцээнг Socket 478, Socket LGA775, Socket 1156, Socket 1366 гэсэн CPU -ны суурь бүхий motherboard ашиглааг. Эх хавтан буюу motherboard сайн байх нь бусад төхөөрөмж найдвартай сайн ажилана гэсэн уг. Эх хавтан нь цаг хугацаа өнгөрөх тусам байнга шинэчилэгдэж байгаа боловч ерөнхий бүтэц нь хэвээр байдаг.

Жишээ болгож дараах байдлаар motherboard дээр байгаа болон холбогдож болох бүх тоног төхөөрөмжк, холбох залгуур тоо ширхэг хүчин чадалыг авч үзлээ. Өөрөөр хэлбэл дараах жишээг харааг та тухайн motherboard дээр ямар CPU, RAM тавьж болох, USB нь ямар хурдтай хэдэн ширхэг байгаа гэх мэт бүх зүйлийг мэдэж авч болно.



Motherboard – Эх хавтан

Motherboard буюу эххавтан нь компьютерийн системийн гол элементүүдийг агуулдаг бөгөөд микропроцессор, санах ой, диск төхөөрөмж, оролт гаралтын төхөөрөмж зэргийг хооронд нь холбож өгдөг чухал төхөөрөмж бөгөөд эдгээр төхөөрөмжүүдийн ул ажиллагааг зохицуулан байдаг. Эх хавтанг Motherboard гэж нэрлэхээс гадна Mainboard гэж нэрлэдэнэ. Motherboard буюу эх хавтанг ямар CPU суурилах боломжтойгоос хамааран дараах байдлаар ангилана.

- Socket PGA370 - Pentium3, Celeron CPU суурилах
- Socket 478 - Pentium 4, түүнтэй агуул Celeron CPU суурилах
- Socket 437 - Atom CPU суурилах /CPU нь суурласан/
- Socket 771 - Xeon CPU суурилах /server зориулалттай/
- Socket LGA775 - Dual Core, Core 2, CPU суурилах
- Socket 1156 - Core i5, Core i7 CPU суурилах
- Socket 1366 - Core i7, Xeon CPU суурилах
- Socket AMD - AMD CPU суурилах

Бид энгийн хэрэгцээнд **Socket 478**, **Socket LGA775**, **Socket 1156**, **Socket 1366** гэсэн CPU -ны суурь бүхий motherboard ашигладаг. Эх хавтан буюу motherboard сайн байх нь бусад төхөөрөмж найдвартай сайн ажилана гэсэн уг. Эх хавтан нь цаг хугацаа өнгөрөх тусам байнга шинэчилэгдэж байгаа боловч ерөнхий бүтэц нь хэвээр байдаг.

Жишээ болгож дараах байдлаар motherboard дээр байгаа болон холбогдож болох бүх тоног төхөөрөмж, холбох залгуур тоо ширхэг хүчин чадалыг авч үзлээ. Өөрөөр хэлбэл дараах жишээг харааг та тухайн motherboard дээр ямар CPU, RAM тавыж болох, USB нь ямар хурдтай хэдэн ширхэг байгаа гэх мэт бүх зүйлийг мэдэж авч болно.



* **CPU:**

- Support for an Intel Core i7 series processor in the LGA 1366 package (Go to CPU Support List for the latest CPU support)
- L3 cache varies with CPU

* **QPI:** 4.8GT/s / 6.4GT/s

* **Chipset:**

- North Bridge: Intel X58 Express Chipset
- South Bridge: Intel ICH10R

* **Memory:**

- 4 x 1.5V DDR3 DIMM sockets supporting up to 16 GB of system memory (Note 1)
- Dual/3 channel memory architecture
- Support for DDR3 2000+/1333/1066/800 MHz memory modules (Go to Memory Support List for the latest memory support list.)

* **Audio:**

- Realtek ALC888 codec
- High Definition Audio
- 2/4/5.1/7.1-channel
- Support for S/PDIF In/Out
- Support for CD In

* **LAN:** 1 x Realtek 8111D chips (10/100/1000 Mbit)

* **Expansion Slots:**

- 2 x PCI Express x16 slots, running at x16 x16 (The PCI Express slots conform to PCI Express 2.0 standard.)
- 1 x PCI Express x4 slot
- 2 x PCI Express x1 slot
- 2 x PCI slots

* **Storage Interface:**

South Bridge: -6 x SATA 3Gb/s connectors (SATA2_0, SATA2_1, SATA2_2, SATA2_3, SATA2_4, SATA2_5) supporting up to 6 SATA 3Gb/s devices



- Support for SATA RAID 0, RAID 1, RAID 5, and RAID 10

GIGABYTE SATA2 chip:

- 1 x IDE connector supporting ATA-133/100/66/33 and up to 2 IDE devices

- 2x SATA 3Gb/s connectors (GSATA2_0, GSATA2_1) supporting up to 2 SATA 3Gb/s devices

- Support for SATA RAID 0, RAID 1 and JBOD

iTE IT8720 chip: 1 x floppy disk drive connector supporting up to 1 floppy disk drive

* IEEE 1394:

- T.I. TSB43AB23 chip

- Up to 3 IEEE 1394a ports (1 on the back panel, 2 via the IEEE 1394a brackets connected to the internal IEEE 1394a headers)

* USB:

- Integrated in the South Bridge

- Up to 12 USB 2.0/1.1 ports (8 on the back panel, 4 via the USB brackets connected to the internal USB headers)

* Internal I/O Connectors:

- 1 x 24-pin ATX main power connector

- 1 x 8-pin ATX 12V power connector

- 1 x floppy disk drive connector

- 1 x IDE connector

- 8 x SATA 3Gb/s connectors

- 1 x CPU fan header

- 3 x system fan headers

- 1 x power fan header

- 1 x North Bridge fan header

- 1 x front panel header

- 1 x front panel audio header

- 1 x CD In connector

- 1 x S/PDIF In header

- 1 x S/PDIF Out header



- 2 x USB 2.0/1.1 headers
- 1 x IEEE 1394a headers
- 1 x serial port header
- 1 x power LED header
- 1 x chassis intrusion header
- 1 x clearing CMOS jumper

* **Back Panel Connectors:**

- 1 x PS/2 keyboard port
- 1 x PS/2 mouse port
- 1 x coaxial S/PDIF Out connector
- 1 x optical S/PDIF Out connector
- 2 x IEEE 1394a port
- 8 x USB 2.0/1.1 ports
- 1 x RJ-45 ports
- 6 x audio jacks (Center/Subwoofer Speaker Out/Rear Speaker Out/Side Speaker Out/Line In/Line Out/Microphone)

* **I/O Controller:** iTE IT8720 chip

* **H/W Monitoring:**



- System voltage detection
- CPU/System/North Bridge temperature detection
- CPU/System/Power fan speed detection
- CPU overheating warning
- CPU/System/Power fan fail warning
- CPU/System fan speed control

* **Form Factor:** ATX Form Factor; 30.5cm x 24.4cm



Персонал компьютерт өнөө **нэг** органоөр ашиглагдаж байгаа motherboard нь ATX загварынх юм. Intel пүнсийн Desktop motherboard, ASUS компани motherboard зэрэг нь хэлэх чанартай ажиллагаатай гэж үзэг.

Motherboard бүтэц схем




Ерөнхий бүтэц хэлбэр
хэмжээ нь адил байгааг
боловч дизайны хувьд
өөр өөр байгаа.




Chipset – Микросхем


Motherboard үйлдвэрлэдэг хэд хэдэн чипс байх бөгөөд Intel, VIA, SIS зэрэг чипийг өргөн ашигладаг. Энэ нь эх хавтангийн хамгийн гол хэсэг.

- Chipset - үндсэн чип
- Input/Output chip - оролт гаралтын чип
- Үндсэн chipset нь эх хавтангын үндсэн үйл ажиллагааг зохицуулан ажиллах бөгөөд Motherboard -ний гол хэсэгт байрлана. Компьютерийн ном сурах бичгээр Northbridge chipset гэж нэрлэдэг. Үндсэн хойт гүүрэн микросхем бөгөөд CPU, RAM, Display card, I/O chipset хоорондын үйл ажиллагааг зохицуулана.
- I/O chip нь оролт гаралтын үйл ажиллагааг хариуцан ажиллана. Үндсэн чипээсараа жижигхэмжээтэй. Компьютерийн ном сурах бичгээр Southbridge chipset гэж нэрлэдэг. Үндсэн ург гүүрэн микросхем ба BIOS, Slot, Port, Disk driver, үндсэн chipset хоорондын үйл ажиллагааг зохицуулана.





Intel P55 Express Chipset бүхий motherboard бусад тоног төхөөрөмж, оролт, гаралт зэрэг нь хэрхэн холбогдохыг жишээ болгож схемээр харууллаа.





Манай улсын тухайг Intel гүүсийн чиптэй Motherboard их ашигладаг бөгөөд энэ төрлийн chip нь дотороо олон хувилбаруудтай. Жишээ нь:

PentiumIII CPU -ний хувьд	Intel 810, 815
PentiumIV CPU -ний хувьд	Intel 845, 848, 865
PentiumD, Core CPU -ний хувьд	Intel 915, 945, 965
Intel Core i3, i5,i7 CPU -ний хувьд	Intel 41, 43, 55, 58

Эдгээр чипнүүд нь дотороо дахин хувилбар болдог. Жишээ нь Intel 815 chip нь 815, 815D, 815E, 815P, 815G, 815GL гэх мэт. Ер нь Intel чипний G, GL, GV хувилбарууд нь onboard байдаг. SIS болон VIA чипний хувьд мөн л олон язнын хувилбартай байдаг.

SLOT – Төхөөрөмжийн суурь

Motherboard дээр байрлах дотоод модем, дэлгэц, дотоод сүлжээ, дууны зэрэг картуудыг суулгадаг суурийг Expansion slots хэлдэг. Энэ нь ISA, AMR, AGP, PCI slot зэрэг төрлиүүдтэй. Сүүлийн veg PCI slot их хэрэглэж байгаа ба PCI нь CPU буюу процессор, санах ойтой шууд холбогддог бөгөөд вүгээрээ bus-тай харьцуулахад процессороос PCI bus дээр суусан картын хооронд өгөглийг хурдан дамжуулдаг.

⦿ CPU slot – CPU сууршлагдаг суурь.

Socket3 - PentiumII CPU

PGA 370 - PentiumIII CPU

PGA 478 - PentiumIV CPU, Celeron CPU

LGA 775 - PIV, PD, CeleronD, Core CPU

LGA 1156, 1366 - Core i3, i5, i7 CPU

⦿ DIMM slot /RAM slot/ - RAM сууршлагдаг суурь.

⦿ AGP slot – AGP буюу дисплэй картны суурь.

⦿ PCI slot – LAN, Модем, FM-TV картуудын суурь

⦿ PCI Express Slot – Сүүлийн veiйн компьютерууд



● IDE Connectors – Hard disk, CDROM, CDWriter, DV-DROM, COMBO, DVDWriter зэргийг залгадаг суурь.

IDE1 буюу Primary анхдагч

IDE2 буюу Secondary хоёрдогч

- Primary суурианд хоёр төхөөрөмж залгах боломжтой бөгөөд Master түвшинтэй, системтэй hard диксийг залгана. Харин зэрэгцүүлэн Slave түвшинтэй CD driver, Hard дикс залгах зориулалттай.

- Secondary суурианд мөн хоёр төхөөрөмж залгах боломжтой бөгөөд Master эсвэл Slave түвшинтэй CD driver, Hard дикс залгах зориулалттай.

● SATA Connectors – SATA hard залгадаг суурь. SATA hard диск залгах суурь нь хэд хэд байдаг. ATA технологитой hard disk SATA технологитой болж байгаа.

● Floppy – Floppy диск драйверыг залгадаг суурь

● ATX Power – Тэжээлийн блокны хүчдэлтэй залгуур

● ATX 12V – Тэжээлийн блокны хүчдэлтэй залгуур

● FAN – Motherboard дээр байрлах 5V, 12V -ийн гаралтууд бөгөөд Процессорт нэмэлт сэнс, төхөөрөмж байрлуулбал энэ гаралтаас хүчдэлээ авна.

● ISA slot - PentiumIII компьютераас өмнөх компьютерийн mohterboard ISA Slot -той байсан. Энд VGA, Sound, LAN, Модем, FM-TV картуудыг сууршуулна.

● AGP slot - AGP карт залгах суурь

● Panel Connectors – Процессорын урд байрлах асааж унтраах Power, Reset товчуур мөн хяналтын улаан, ногоон гэрэл нь энэ хэсэгт холбогдоно.



● USB Headers – Процессорын урд байрлах USB port -ийг залгана. Энэ нь хөдөлмөр хөнгөвчилсөн залгуур бөгөөд USB1.0, USB2.0 хувилбартай байдаг.

● CD - In Headers – CD драйверийн дууны гаралтыг залгана. Дууны CD-г сонгоход хэрэглэгдэнэ.



PORT – Портууд

Эх хавтаны арг байрлах гадааг тоног тохөөрөмж залгахад зориулагдсан залгуурыг port /порт/ гэнэ. Энд гар, хулгана, принтер, скайнер ээргийг залгана.





PS/2 port - Гар, хулгана залгана. Гар ягаан өнгөтэй, хулгана нь ногоон өнгөтэй порттой.

СОМ буюу **Serial port** - Энд хулгана, принтер, скайнер болон бусад төхөөрөмж залгана.

LPT буюу **Parallel port** - Энд принтер, скайнер болон бусад төхөөрөмж залгана.

USB port - Энд сүүлийн чийн бүх төхөөрөмжийг залгана. Жишээ нь: Гар, хулгана, принтер, скайнер, flash, mp3 гар USB port нь USB1.0, USB2.0, USB3.0 гэсэн хувилбартай байдаг.

RJ-45 port - Сүлжээний утас залгах

VGA port - Энэ нь onboard дисплей картны залгуур

Sound port - Дууны төхөөрөмж залгах залгуурууд.

Fire Wire IEEE1394 port - USB портны дараа гарч ирсэн өндөр хурдтай мэдээлэл дамжуулагч порт. Ихэвчилэн Video камераас дурс компьютерт оруулахад хэрэглэдэг.


SATA3 - Нэмэлтээр сүүлийн чийн motherboard дээр байрлах болсон бөгөөд энэ нь шууд SATA хард диск бусад төхөөрөмжийг холбох боломжтой бөөөд өндөр хурдаар мэдээлэл дамжуулах боломжтой.

Эдгээрээс гадна бүх тоног төхөөрөмж бүр өөр өөрийн гэсэн залгах залгуурны суурь /port/ байдаг. Тиймээс тэр залгуураар нь төхөөрөмжийг таних боломжтой. Жишээ нь сүлжээ карт гэхэд 8 сувагтай байхад, модем 4 сувагтай ерөнхийдөө төстэй картууд байдаг.



Нэмэлт картууд


Өөр өөрийн гэсэн онцлог нүрэгтэй, бие даасан оролт гаралтай төхөөрөмжүүдийг хэлнэ. Картууд нь Motherboard дээр Expansion slot ашиглан сууринна.



VGA, AGP,
display card



modem



sound card



lan card




1394 card



wireless card



TV-FM card



USB card




Lan card – Сүлжээ карт

Энэтхээрэмж нь компьютерууд хоорондоо холбогдож мэдээлэл солилцоход хэрэглэгдэнэ. Бүх сүлжээний карт нэг нь нөгөөтөөгөө давхцахааргүй **MAC** хаяглалттай байдаг. Энэ хаягийг ашиглан сүлжээн дэх компьютерууд хоорондоо өгөгдөл дамжуулалтыг хянааг.

Дотоод сүлжээний карт (мөн **network adapter** ч гэж нэрлэдэг) нь компьютерийн **motherboard** дахь **expansion slot** буюу **ISA**, **PCI slot** ашиглан сууринна. Дотоод сүлжээний картын хурдыг нь **megabyte** нэгжээр хэмжинэ. Манайг **Realtek** компаний **100Mbps** хурдтайг картыг ихэвчилэн ашигладаг. Ер нь бол **10Mbps/100Mbps/1000Mbps** гэсэн хурдтай байдаг. Сүлжээ картны портыг **RJ-45 port** гэж нэрлэдэг.


Сүлжээ карт нь сүүлийн **PCI** motherboard дээр сууринсан байдаг. Харин **НЭМЭЛТ**ээр тавихын тулд карт, **USB**, **Wireless** сүлжээ картыг ашиглана. Харин зөөврийн компьютерт бол **PCMCIA**, **USB**, **Wireless** сүлжээ картыг нэмэлтээр тавьж болдог.





Sound card – Дууны Карт

Энэ карт нь дууг компьютераас speaker буюу чанга яригчруу гаргах мөн микрофоны тусламжтайгаар дууг компьютерт бичиж хадгалах боломжийг олгодог. Уг картыг компьютер дотор байрлах expansion slot-г суулгадаг. Дууны карт нь ISA эсвэл PCI төрлийн слот бүхий байж болно. Бараг бүх дууны карт нь дууг электрон хувилбараар гаргадаг стандарт болох MIDI-г ашигладаг.



Speaker Port - Speaker /chanга яригч/, чихэвч, микрофон зэргийг залгана.

Speaker Out - Дууны гаралт

Line Out - Нэмэлт гаралт

Line In - Нэмэлт оролт FM, TV карт зэргийг холбоно.

Mic - Микрофоны оролт

Joystick - Тоглоомын нэмэлт төхөөрөмж залгана.

CD Audio Out Port - CD driver -ийн дууны оролт залган

Sound Card Chipset - Дууны картны үндсэн чип. Энэ ямар нэр, төрөл, хувилбартай гэгтийг мэдэхэд хэрэглэнэ. Мон дууны картыг үйлслийн системд таниулсан ажиллуулахад энэ их хэрэгтэй.




Display card & AGP card

Энэ төхөөрөмж нь дэлгэцийг эх хавтантай холбож отх бөгөөд микропроцессорын хийж байгааүйлдэл, программ хангамжийг хэрэглэгчдээд харуулах уурэгтэй.

Тус карт нь өөрийн дотоод санах ойтой. Санах ойн хэмжээ нь их байх нь компьютерийн видео дурслэх чадвар нь сайн байна гэсэн уг. **32MB, 64MB, 128MB, ...1GB** хүртэл хэмжээтэй санах ой бүхий Display карт хэрэглэж байна.

Video дурслэх хэлбэр нь 2D хэмжээстэй ба энэ төхөөрөмжийг сайжруулан 3D хэмжээстэй **AGP card, PCI Express Video Card** гарсан. Эдгээр карт нь 3-н хэмжээстэй програм болон тоглоомтой ажиллахад зориулагдсан.



DVI port - Дэлгэц болон бусад төхөөрөмж залгах

TV Out - Телевизор залгаж дэлгэцний оронд ашиглах

Display Out - Стандарт дэлгэц залгах

Cooler - Хөргөлтийн сэнс

Display chipset - Display картны үндсэн чип. Энэ ямар нэр, төрөл, хувилбартай гэгийг мэдэхэд хэрэглэнэ. Мөн display картыг үйлдлийн системд таниулахад ашиглана.


Ер нь ATI, Nvidia зэрэг Display chipset үйлдвэрлэгч байдаг. Манаигүйд эдгээрээс Nvidia Geforce чиптэй олон янзын хувилбарыг хэрэглэж байгаа.




Modem card

Энэ төхөөрөмж нь компьютерт боловсруулсан өгөгдлийг телефон шугамаар дамжуулахын тулд аналоги руу хувиргаж модуляци хийх нүрэгтэй. Мөн телефон шугамаар дамжин ирсэн аналоги сигналыг компьютерт хүлээн авахдаа тоон сигнал руу хувирган демодуляци хийдэг.

Modem нь Modulator Demodulator гэсэн угний товчлол бөгөөд гадааг дотоог гэж 2 ангилаа. Модем нь Voice modem, Fax modem, Error correction, Data compression, Flow control гэсэн олон төрөл байна. Модемын мэдээлэл дамжуулах хурдыг bps (bit per second) нэгжээр хэмжинэ. Манаид 56Kbps хурдтайг ашиглаж байна. Мөн өндөр хурдны xDSL системийн модемыг ашиглах болсон. xDSL технологи нь компьютераас ирж буй тоон мэдээллийг аналоги сигнал руу хувиргах шаардлагагүй бөгөөд шууд тоон сигналыг дамжуулдгаараа мэдээллийг өргөн зурваст өндөр хурдаар хүргэх боломжтой.



DSL, ADSL modem




modem card

USB modem




TV card, FM card эсвэл TV-FM card

Энэ төхөөрөмж нь компьютерийг ашиглаж Телевизор үзэхэд, FM сонсоход хэрэглэнэ. TV болон FM картууд нь дангаар ба хосоороо байдаг. TV карт кабелийн сувагтай холбогдох эсвэл антены тусламжтайгаар телевизорын сувгуудыг татдаг. Дуу авиааг нь Sound картны тусламжаар гаргана. FM карт нь FM сувгийг антены тусламжтай хүлээн авч Sound карт ашиглан дуу авиааг гаргана.




Зөөврийн
компьютерийн
TV card






Port агуулсан card

USB, Fire Wire 1394, LPT, COM, DV гэх мэт портуудыг байхгүй бол нэмэхэд хэрэглэнэ. Ялангуяа USB портоор олон төхөөрөмж залгаж байгаа болохоор USB port олон хэрэгтэй байдаг.



Video card

Компьютерийг видео дүрстэй ажиллах чадварыг нэмэгдүүлдэг мэргэжлийн карт. Энэхүү картын тусламжтайгаар видео мантааж хийх, клип, кино, реклам зэргийг хийх боломжтой. Мөн бүх төрлийн видео эхүүсвэртэй ажиллана. Өөрөөр хэлбэл хальснаас компьютерт видеос оруулах, TV -ээс бичлэг хальс болон CD дээр хуулж авах зэрэгт хэрэглэнэ.





Гаралтын төхөөрөмж

Микропроцессорын боловсруулсан мэдээллийн нийтийг ямар нэгэн хэлбэрээр бидэнд хүргэж ойлгуулдаг тохөөрөмжүүд энд багтана. Эдгээр нь голдуу гадаад төхөөрөмжүүд юм.

Дэлгэц – Monitor

Дэлгэц нь мэдээллийг дурс хэлбэрээр харуулах, гаргах ширэгтэй. Процессорын хийж байгаа бүх үйлдэл, диск төхөөрөмжүүд дээрх файл, програмуудыг мониторын тусланжтай харна. Display (дисплей) нь мониторын экран бөгөөд харцагаан, өнгөт, шингэн кристалл зэрэг төрлийтэй байдаг.



Өнөөдөр ихэвчлэн VGA (Video Graphics Adapter), SVGA (Super Video Graphics Adapter) зэрэг дисплейг хэрэглэхээс гадна LCD буюу шингэн кристалл дисплей бүхий монитор хэрэглэж эхлээд байна. Дэлгэцийг овор хэмжээнийх нь хувьд ич нэгжээр хэмждэг. Манаад 17, 19 ичийн дэлгэцүүд өргөн хэрэглэгддэг. Хэдэн өнгөөр хэр сайн өнгө ялгаруулалт хийж байгаагаар нь resolution буюу өнгөний нээлтийг тодорхойлно.

Таны хэрэглэж байгаа дэлгэц нь 15 ичийн дисплейтэй бол 32bitcolor буюу 32,000,000 өнгийг 1024x768 pixel-тэйгээр сонгох боломжтой байвал тохиromжтой. Гэхдээ дисплейний хэмжээнээс хамааран дурслэх цэгийн нягтралыг тохируулна.



Хэвлэгч-Printer

Боловсруулсан мэдээллийг цаасан дээр буулгахад зориулагдсан төхөөрөмж. Хэвлэгч нь өнгөт, хар гэсэн төрлүүстэй. Принтерийг дотор нь хэвлэх төрлөөр нь:

- dot-matrix буюу матрицын принтер
- inkjet буюу бэхэн хортой принтер
- laser буюу лазерийн принтер гэж ангилдаг.

Лазерийн принтер нь эдийн засгийн хувьд их хэмнэлттэй байдаг учир их хэрэглэгэдэг. Мөн фото зураг хэвлэхэд зориулагдсан PhotoPrinter байдаг. Фото принтер нь inkjet буюу бэхэн хортой байдаг. Гэхдээ хор болон хэвлэх нягтрал нь ердийн өнгөт принтерийг бодоход сайн байдаг. Мөн фото цаасан дээр маш нягтрал сайтай хэвлэдэг.

Сүүлийн veg олон уйлдэлтэй принтерийг олноор уйлдвэрлэн гаргаж байгаа билээ. Энэ принтер нь хэвлэх төдийгүй хувилах, факс дамжуулах, хүлээн авах, сканердах зэрэг уйлдвэрлэгдсээр байгаа.


Принтер нь компьютерт LPT, USB гэсэн 2 төрлийн портоор залгадаг. Принтерийг HP буюу Hewlett Packard, Epson, Xerox зэрэг пүүсвүүд уйлдвэрлэн гаргадаг. Жишээлбэл: Epson Stylus Color440, HP DeskJet612C, HP LaserJet 1100, Xerox DocuPrint C11 гэх мэт.





Том хэмжээний хулдаас,
даавуун дээр хэвлэгч

Лазерын принтерийн бүтэц
ажиллах зарчмын





Принтерийн чанарыг үнэлэх хүчин зүйлүүд:

- ➊ DPI /Resolution/ буюу нягтрал
- ➋ Хэвлэх хург
- ➌ Санах ой
- ➍ Цаасны формат /төрөл/ гэх мэтээр хэмжинэ.

- **Resolution** (өнгөний ялгарал) Принтерийн өнгөний ялгарал нь ихэвчлэн dpi (dots per inch) буюу нэг инчид ноогдох цэгийн тоогоор хэмжигддэг. Жишээ нь принтерийн өнгөний ялгарлын тохиргоог 150 dpi болгоод нэг хуудас хэвлэх, мөн 300 dpi болгоод өөр нэг хуудас дээр нэг шжил текстийг хэвлэхэд 300 dpi тохируулгаар хэвлэсэн хуудас нөгөөгөөсөө илүү тод харагддаг.

-**Хэвлэххург**: Нэг хуудсыг хэвлэн гаргах хугацааг хэлнэ. Ихээхэн хэмжээний материал хэвлэхэд хург ихтэй байх шаардлагатай байдаг. Өнгөт принтерийн хург удаан байдаг байна. Үнэ өртөг ихтэй принтерүүд ихэвчлэн хург ихтэй түргэн хэвлэдэг байна.


- **Санах ой**: Ихэнх принтерүүд багахан хэмжээний санах ойтой ирдэг байна. Жишээлбэл 4Mb гэх мэт. Өөрийн гэсэн санах ойтой принтер нь 4Mb, зурагтай болон хувцасыг хамгаалахад хурдан хэвлэдэг. Мөн сүлжээнд хэрэглэхэд тохиромжтой байдаг.

- **Хэвлэх цаасны хэмжээ, хэлбэр** Принтер нь хэвлэх цаасны төрөл, хэлбэр хэмжээ нь олон янз байвал илүү хөдөлмөр хөнгөвчилдэг. Жишээ нь: Цаас зузаан, нимгэн, өргөн, нарийн байх. Мөн стандарт хэмжээ нь A4, A3, A5, A4 гэх мэтээс гадна стандарт бус олон төрлийн цаас дээр хэвлэх боломжтой бол сайн. Цааснаас гадна слайд, калик гэх мэт дээр хэвлэх боломжтой байх хэрэгтэй.



Өсгөгч-Speaker


Компьютерт байгаа дуу авцаг сонсоход зориулагдсан төхөөрөмж, Сүүлг Speaker -ийг сайжруулан Subwoofer гэдэг төхөөрөмжийг илүү их хэрэглэх болсон. Энэ төхөөрөмж нь дуу авиаанд шүүлт хийдэг. Өсгөгчоос гадна headphone буюу чихэвч ашиглаж дуу сонсох боломжтой. Чихэвч нь дуу авиа сонсохоос гадна давхар микрофонтой байдаг. Тэр микрофоныг ашиглан дууг компьютерт оруулах улмаар интернетээр ярих, хэлний хичээл хийх зэрэгт өргөн хэрэглэж байна.





Тэжээлийн блок – Power Supply

Компьютерт тэжээлийг хангах нүрэгтэй. Тэжээлийн блокоос Motherboard, Hard disk, CD drivers гэх мэт бүх эд ангиудыг тэжээлээр хангана. Ер нь бол 220V -ийг компьютерийн эд ангиудын ажиллаж чадах хэмжээнд бууруулан тохиулана. Компьютерийн эд ангиуд нь 12V, 5V, 3.5V гэх мэт бага хэмжээтэй тэжээл хэрэгтэй. байдаг.

Тэжээлийн блок нь янз янзын чадалтай байдаг. Чадал их байх нь тусмаа сайн ажиллана. Ялангуяа олон төхөөрөмж залгасан тохиолдолд их хэрэгтэй. Ойролцоогоор PIII - 300W P4, D, Core - 400W, Core i3, i5, i7 - 500W байх нь тохиромжтой.



Connectors included in the power supply...



ATX 20/24 - Эх хавтаны үндсэн тэжээл 1 ш байдаг

P4 ATX 12V - Эх хавтаны нэмэлт тэжээл 1 ш байдаг

IDE 4 PIN - Hard disk, CD drivers -ийн тэжээл 4ш дээш

Floppy 4 PIN - Уян диксний тэжээл 1 ш байдаг

SATA - SATA hard disk -ний тэжээл олон



Color	Signal	Pin	Pin	Signal	Color
Orange	+3.3 V	1	13	+3.3 V	Orange
Orange	+3.3 V	2	14	+3.3 V sense	Brown
Black	Ground	3	15	-12 V	Blue
Red	+5 V	4	16	Ground	Black
Black	Ground	5	17	Power on	Green
Red	+5 V	6	18	Ground	Black
Black	Ground	7	19	Ground	Black
Grey	Power good	8	20	No connection	Black
Purple	+5 V standby	9	21	+5 V	Red
Yellow	+12 V	10	22	+5 V	Red
Yellow	+12 V	11	23	+5 V	Red
Orange	+3.3 V	12	24	Ground	Black




Хөргөлтын систем – Cooler

Компьютерийн эд ангиуд ажиллах явцад дулаан ялгаруулан их халдаг учир үүнийг хүйтэн байлагах ширэгтэй сэнсийг Cooler гэнэ. CPU, Motherboard chipset, AGP card, PCI Express Video card, Video card, Power Supply зэрэг нь хөргөлтийн сэнстэй байдаг.


Мөн нэмэж процессор дотор сэнс байрлуулж болно. CPU cooler -ийн чадал CPU -ний хүчин чадлаас хамаардаг. Жишээ нь: Cooler -ний хайрцаг дагалдах ном /цаасан/ дээр хөргөж чадах CPU -ний нэр үзүүлтийг бичсэн байдаг. Жишээ нь: Can be used for CPU: -Up to Intel Celeron D 2.8GHz, Up to Intel Pentium IV 2.4GHz гэж бичсэн байна.



Intel Core, Intel i7
cooler



Display card cooler



Нэмэлтээр тавигдаг
cooler




Хадгалах байгууламж


Компьютерийн мэдээлэл гэдгээр боловсруулсан файл, программ хангамжийг бурдуулэгч файлууд зэргийг ойлгох бөгөөд эдгээрийг хадгалж, агуулах төхөөрөмжийг хадгалах байгууламж ба диск гэнэ. Одоогоор өргөн хэрэглэгдэж байгаа 6 төрлийн диск төхөөрөмж байгаа




Hard disk- HD (Хатуу диск)




Floppy disk-FD
(Уян диск)




ZIP disk



Flash disk



CD (Компакт диск)



Memory disk




Диск төхөөрөмжийн хүчин чадал

Нэр	Хэмжээ:	Үнших, Бичих төхөөрөмж:
Floppy	1.44MB	Floppy driver
Hard ATA	20MB-750GB	IDE залгуур
Hard SATA	80GB-2TB	SATA залгуур
CDR	750MB орчим	Бүх CD Drivers
DVD CD	4.7GB...	DVDROM, DVDWRITER
Blu-Ray CD	30GB...	Blu-Ray driver
ZIP	250MB орчим	Zip driver
Flash, MP3, MP4	32MB-16GB...	USB port
IPOD	512MB-30GB...	USB port
Memory card	16MB-16GB...	USB port

Floppy disk – Уян диск

Ихэвчлэн мэдээллийг зөөвөрлөхөд зориулсан байдал бөгөөд ямар ч зориулалтаар хэрэглэж болно. FD нь соронзон оптик буюу соронзон орны тусламжтайгаар биетийн оптик чанарыг өөрчлох аргаг тулгуурлагдан хийгдсэн байна. Floppy disk буюу уян дискний уншдаг, бичдэг төхөөрөмжийг нь FDD (Floppy Disk Driver) гэж нэрлэнэ. Мөн A disk ч гэж нэрлэнэ. Сүүлийн үеэг хэрэглэхээ болж байгаа ба компьютерууд уян дискний төхөөрөмжгүй түлдвэрлэгдэж байна.





Hard disk – Хатуу диск /IDE-ATA/


Энэ төрлийн дикс нь харьцангуйгаар багтаамж ихтэй бөгөөд компьютерийн системийн диск болгож хэрэглэдэг. Нэг компьютерт 1 - 4 ширхэг хатуу дикс зэрэгцүүлэн суулгаж болно. Хатуу дискийг системийн зориулалтаар компьютерт заавал нэгийг байрлуулан түнх дээрээ үйлслийн систем, хэрэглээний програмуудаа суулгаж хэрэглэнэ.

Мөн хатуу дикс дээр хэрэгтэй мэдээллээ хуулаад нөөц хэлбэрээр хэрэглэж болно.


Хатуу дикс нь нэг талдаа микросхем бүхий удирдах хэсэгтэй, гадааг талаараа соронзон орноос хамгаалах хөнгөнцагаан бүрхүүлтэй дотоод талдаа вакум орчинд диксэн толь болон түүнийг уншигч толгой зэргээс бүрдэнэ.

Хатуу дискийг голчлон Seagate, Quantum, Maxtor, Fujitsu, Samsung, Western Digital фирмүүд оор өөрсдийн технологийг ашиглан үйлдвэрлэдэг.

ATA гэдэг нь Advanced Technology Attachment нийт товчлол бөгөөд энэ төрлийн дискийг ашиглах нь багасаж SATA төрлийн дискийг ашиглагдаж байгаа.



Motherboard дээрх ATA hard disk залгах суурь




ATA hard disk data буюу өгөгдөл дамжуулах кабел




Hard Jumber – Тохиргоо хийх

IDE буюу ATA технологитой хатуу диск нь нэг түүзэн кабел дээр хоёр хард диск залгадаг. Тиймээс энэ хоёр хардны ажиллах зарчим нь

Master - удирдах, **Slave** - дагалдах гэсэн түвшингэй. Хатуу диск дээр master, slave түвшинг тохирнуулдаг зүйлийг JUMPER гэнэ. jumper -ний ажиллах зарчим нь хэлхээг салгах, ийшлүүлэх нүрэгтэй бөгөөд зааварын дагуу тухайн байрлалд нь шилжүүлэн хийж ашиглана.



Тухайн хатуу дискний аль нэг хэсэгт байх тохиргооны хувснэгтийг ашиглаж өөрчилнө. Бид 2 янзын жишээ авлаа.






Motherboard -тай холбогдох

Master hard залгах

Slave hard залгах



IDE1 буюу Primary
залгах суурь

IDE2 буюу Secondary
залгах суурь

Motherboard нь IDE залгах түүзэн кабелын суурь хоёр байх бөгөөд Primary, Secondary гэсэн түвшинд ажиллана. Hard disk Master, Slave гэсэн түвшинд ажиллана. Тиймээс

Primary Master

Primary Slave

Secondary Master

Secondary Slave

Гэсэн 4-н түвшин болж ажиллана. Систем суусан хатуу диск нь заавал Primary Master түвшинтэй байх ёстой. Бусад нь ямар ч байж болно.

Гэхдээ нэг түүзэн кабел дээр **хоёр master, хоёр slave** байж болохгүйг анхаарах хэрэгтэй. Мөн hard diskнээс гадна CDROM, CD Writer, DVDROM, COMBO, DVDWriter, Zip driver зэрэг төхөөрөмж IDE залгуур дээр хатуу дисктэй зэрэгцэн залгагдана.



Hard disk – Хатуу диск /SATA/

Сүүлийн *veg* компьютер ATA /Advanced Technology Attachment/ технологитой хатуу диск нь SATA буюу SerialATA технологитой болсон. Энэ нь нэг компьютерт 1 - 6 ширхэгийг зэрэгцүүлэн суулгаж болно. SATA хатуу диск нь ATA хатуу дисктэй ерөнхийдоо ашил хийгдсэн.

SATA Revision 1.0 (SATA 1.5 Gbit/s)

SATA Revision 2.0 (SATA 3 Gbit/s)

SATA Revision 3.0 (SATA 6 Gbit/s)

eSATA


Гэсэн холболтийн технологиудыг хэрэглэж байгаа. Өөрөөр хэлбэл эдгээр нь ерөнхий хэлбэрийн хувьд ашиглагч мэдээлэл хуулах, дамжуулах *veg* хурдны ялгаатай гэсэн уг юмаа.




Motherboard дээрх SATA hard disk залгах суурь



SATA hard disk data буюу өгөгдөл дамжуулах кабел




SATA hard disk дээр data буюу өгөгдөл дамжуулах кабел, тэжээлийн кабел залгасан байгаа нь



eSATA - энэ технологи нь сүүлийн veg ашиглах болоод байгаа бөгөөд шууд компьютерийн гадна талаас хатуу диск бусад төхөөрөмж залгах боломж олгодог. Голдуу зөөврийн компьютерт шилж ашиглагдаж байгаа.

Hard disk бүтэц






- Base Casting – Hard diskний гадар хөнгөн цагаан
- Spindle – дискний гол
- Slider and Head – Мэдээлэл уншигч толгой.
- Actuator Arm – Мэдээлэл уншигчийн гар.
- Actuator Axis – Уншигчийн хөдөлгөгч тэнхлэг
- Actuator – Хөдөлгөгч. Мэдээлэл уншигч толгой
гар зэрэг нь энд бэхлэгдсэн байна.
- Platter – Hard diskний дотор талд байрлах диск.
Энэ дискэн дээр мэдээлэл бичигдэнэ.
Компьютер асаалттай нэг диск эргэлдэнэ.
- Ribbon Cable – Диск дээрх мэдээллийг
микросхемд өгөгдөл болгон өгөх кабел
- Cover Mounting Holes – Бэхлэх боолтны нүх
- IDE Connector – IDE болон hard diskийг холбох
туузан кабел энд холбоно. Энэ холболтыг
хийснээр hard disk Motherboard буюу эх
хавтантай холбогдох болно.
- Power Connector – Тэжээлийн блокоос гарсан
тэжээл залгуурыг энд залгана.
- Jumper – Тохиргоо хийх хэсэг

Portable Hard disk – Зөөврийн Хатуу диск

Хэмжээний хувьд их бөгөөд мэдээлэл хадгалах зөөврөлөхөд зориулагдсан хатуу диск бөгөөд USB залгуураар дурын компьютерт холбогдох боломжтой.






ZIP диск

Компьютер дэх файлуудыг архивлах, хуулж авахад зориулсан жижиг авсаархан төхөөрөмж юм. Ихэвчлэн Iomega корпораци zip disk төхөөрөмжийг **үйлдвэрлэдэг**.

Zip disk төхөөрөмжийг өргөн ашигладаггүй боловч хэзээ нэг цагт хэрэглэхүүц файл хадгалахад, зарим vez хэрэг болох том хэмжээний файлууд /төрөл **бурийн** график зургуудыг хадгалахад, бусадтай их хэмжээнүүдийг файлуудыг/ солилцоход зэрэгт ашигладаг.



Zip дискний уншдаг, бичсэг төхөөрөмжийг нь Zip Drive гэж нэрлэнэ. Zip drive нь гадааг дотоод **Гэсэн 2** төрөл байна.

Гадааг Zip driver - LPT, USB port

Дотоод Zip driver - SCSI IDE

Гадааг нь зөөвөрлөхөд зориулагдсан бөгөөд LPT, USB port ашиглаж компьютерт холбогдоно. Дотоод нь процессор дотор байрлах бөгөөд SCSI (Small Computer System Interface) ашиглаж холбогдоно. Сүллийн vez DVD CD, Flash, Memory card зэрэг хэрэглэхэд хялбар хэмжээ ихтэй диск төхөөрөмж их гарсан болохоор ZIP дискийг хэрэглэхээс болж байгаа.



Flash disk, MP3, MP4

Сүүлд шинээр маш хүчтэй гарч ирж байгаа бөгөөд хэрэглэх, зөөхөд хялбар хийгдсэн диск юм. Энэ диск нь түлхүүрийн эннэлт шиг хэмжээбөгөөд USB port-той компьютерт шууд холбож хэрэглэнэ. Floppy дискний оронд гарч ирсэн диск бөгөөд хэрэглэхдэд илүү хялбар тохиromжтой юм. Гол хэрэглээ нь компьютер хооронд мэдээлэл зөөхөд хэрэглэнэ.



Flash



MP3



MP4

Сүүлийн чөийн flash диск нь илүү боловсронгуй болж MP3, MP4 болж дууны mp3 формат, видеоны mp4 формат, зэргийг уншдаг болж хөгжсөн. Өөрөөр хэлбэл flash дискний хэрэглээ нь илүү өргөн болсон. Мэдээлэл хадгалах, зөөх, дууны болон видео файл тоглуулах, мөн FM сонсох гэх мэтээр хэрэглээ нэмэгдсээр байна.

Өргөн хэрэглээний төхөөрөмж болсон болохоор үзэг, цаг түлхүүрийн оосор зэрэгт flash дискийг давхар агуулсан хэлбэрээр үйлдвэрлэж байна.



Flash - тай үзэг



Flash - тай цаг




Memory disk

Дижитал камерт зориулагдсан диск юм. Энэ диск нь овор хэмжээний хувьд маш жижиг боловч дотоод багтаамж нь их байдаг онцлогтой юм. Бүх төрлийн дижитал камер энэ дискний тусламжтай зураг болон дурс бичлэгийг хадгална. Ийм хэлбэрийн диск нь сувлийн veg их үйлдвэрлэгдэж байгаа. Гар утас, цаг зэрэгт байрлаж дуу болон зураг хадгалж ашиглахад хэрэглэнэ. Өөрөөр хэлбэл дуу сонсох, клип үзэх гэх мэт.

Memory card нь SD, MD, MMC гэх мэт олон төрөлтэй. Хэмжээний хувьд 16MB - 4GB хүртэл янз бүр байдаг.



Олон төрлийн картууд дээр байгаа мэдээллийг компьютерт оруулахдаа Card Reader буюу карт уншигч ашигладаг. Эсвэл дижитал эх үүсвэр, гар утас зэрэг төхөөрөмжийг нь зориулалтын залгуур утсаар холбох замаар мэдээллийг нь компьютерт оруулна.





CD – Compact Disk
DVD – Digital Versatile Disk
BD – Blu Ray Disk

Мэдээллийг хадгалахад тохиromжтой бөгөөд лазерийн гэрлийн тусламжтайгаар уншиж бичдэг. Технологийн хувьд CD, DVD, BluRay гэсэн хоёр төрөл байна. CD нь хэмжээний хувьд бага мэдээлэл агуулах, DVD нь их хэмжээтэй мэдээллийг агуулах боломжтой бөгөөд сунгуүний veg BluRay гэсэн шинч төхөөрөмж гарсанаар маш их хэмжээний мэдээлэлийг агуулах боломжтой болоод байна.

CD - 700MB орчим

DVD - 4.7GB дээш

BD - 25GB дээш

CD -г ашиглах хэлбэрээр нь

audio (дууны)

data (програм, тоглоом, mp3...)

vcd (кино, клип)

DVD -г ашиглах хэлбэрээр нь

data (програм, тоглоом..)

dvd (кино, клип) гэж ангилна.

BluRay -г ашиглах хэлбэрээр нь

data (програм, тоглоом..)

video (кино, клип) гэж ангилна.

CD нь дотроо

CD-R /CD-Recordable/ - нэг удаа бичилт хийх

CD-RW /CD-ReWritable/ олон удаа бичилт хийх

DVD нь дотроо

DVD-R, DVD+R /DVD-Recordable/ - нэг удаа бичилт хийх

DVD-RW, DVD-RAM /CD-ReWritable/ олон удаа бичилт хийх

BluRay нь дотроо

DB-R - нэг удаа бичилт хийх

DBRE - олон удаа бичилт хийх



CD, DVD, Blu-Ray -ний нэг тал нь бичилт хийгдэх хэсэг нөгөө тал нь хаяг бичихэд зориулагдсан. Хаяг бичиг хэсэгт тухайн дискний хэмжээ, төрөл, бичих болон унших хурдыг тодорхой бичсэн байдаг.

CD DRIVERS

Дээр үзсэн компакт дискуудийг унших, бичихэд хэрэглэдэг төхөөрөмжүүдийг **CD driver** гэх ба дараах байдлаар ангилна. Эдгээр нь компьютерт суурьласан байх хэрэгтэй.



CD-ROM	- зөвхөн унших /CD-R, CD-RW/
CD-Writer	- унших, бичих /CD-R, CD-RW/
DVD-ROM	- зөвхөн унших /CD, DVD/
Combo ROM	- DVD ROM, CD Writer хавсарсан
DVD-Writer	- унших, бичих /CD, DVD/
Blu-Ray	- унших, бичих /CD, DVD, Blu-Ray/

Дээрх CD уншдаг бичдэг төхөөрөмжүүд нь компакт дискийг унших бичих хурдтай байна. Хурд нь 1x, 4x, 8x, 16x, 24x, 32x, 40x, 52x зэрэг байдаг. 1x гэдэг нь өгөгдөл хандах хурд нь секундээд 150kb юм.

Энэ хурдыг сайн тохицуулан бичих хэрэгтэй. Яагаад гэвэл бичсэний дараа CD -гээ унших ямар нэг төхөөрөмжөнд хийхэд түүнийг уншиж чадахгүй байх тал байна. Жишээ нь машины CD уншдаг хөгжим нь 24x орчимоор бичсэн cd -г уншдаг.

Машины хөгжим, CD Player, CD уншдаг хөгжим, VCD болон DVD тоглуулагч зэргийн CD унших хурднаас хамаарч бичиж байгаа CD -ний хурдыг тохиуулах хэрэгтэй. Ялангуяа үйлдвэрлээд хэдэн жил болж байгаа төхөөрөмж нь хурд багатай бичсэн CD уншдаг болохыг анхаарна уу.

DVD ба BluRay нь сүүлийн үеийн өндөр нарийвчлалтай бичилт хийдэг учир бичих унших хурд нь бага байдаг. Цаашиг сайжиран илүү хурдан болно.






iPOD

Apple компани бүтээгдэхүүн бөгөөд сүүлийн үед нэлээд хэрэглээ болж байгаа төхөөрөмж юм. Энэ төхөөрөмж нь анх 2001 оны 10 сарын 10-нд шилдэгээр лэгдсэн. Ерөнхийдөө MP4 -тэй ашил. Гэхдээ хэмжээний хувьд их мэдээлэл агуулана. Дуу, дурс, зураг зэргийг узэх, тоглуулахад зориулагдсан төхөөрөмж.

Windwos шилдлийн системийн ердийн дууны, видео файлуудыг шууд iPod дээр ашиглах боломжгүй байдаг бөгөөд хөрвүүлэгч програмын тусламжтай хөрвүүлэлт хийнэ. Ийм хөрвүүлэгч програм нь iTunes юм.




iPOD -той ажиллахад зориулагдсан iTunes програм



UPS

Компьютерийн тэжээлийг тодорхой хугацаанг барьж байхад зориулагдсан төхөөрөмжийг Uninterruptible Power Supply - UPS гэнэ. Энэ нь компьютерт ирж байгаа хүчдэлийг тогтвортой байлгах, мөн тэжээл тасрах үе^g хэдэн минут тэжээлийг компьютерт өгч байх зэрэг үйлдэл гүйцэтгэнэ.

Тэжээл тасрасан үе^g компьютер дээр хийж байсан зүйлээ хадгалах, мөн компьютерээ зөв унтраах зэрэг маш их хэрэгтэй төхөөрөмж юм.



Хэдэн компьютер залгаж тэжээл авах боломжтой. Хэдэн ватт чадалтай зэргээр нь хүчин чадлыг хэмжинэ.

JOYSTICK

Компьютерт нэмэлтээр залгаж тоглоом тоглоход зориулагдсан гарын Joystick гэнэ. Joystick ашиглаж тоглоом тоглох нь компьютерийн үндсэн гар хулгана - ашиглаж тоглохоосоо илүү сонирхолтой бодитой байдаг. Joystick нь sound card -ний нэмэлт порт болох Game Port залгана.





Компьютерийн хэмжих нэгж

Мэдээлэл агуулах багтаамж:

- Компьютерт мэдээллийн багтаамжийг byte нэгжээр хэмжинэ. Компьютер нь мэдээллийг 2-т тооллын систем дээр дурслэх ба энэ нь 0, 1 гэсэн хоёр тэмдэгтээс бурдэнэ. 2 - т тооллын системийн 1 тэмдэгтийг 1 bit /бит/ мэдээлэл гэнэ. Энэ нь мэдээлэл хэмжих хамгийн бага нэгж юм. Тэгэхээр компьютер ашиглагдаж байгаа дууны, текстэн, зурган, системийн гэх мэт бүх файлууд нь компьютерт 0 ба 1 гэсэн 2-тын тоололын системээр бичигдсэн байдаг.

1Byte=8Bit- тэй тэнцдэг.

1024 Byte = 1 Kilo Byte (1 KB)

1024 KB = 1 Mega Byte (1MB)

1024 MB = 1 Gega Byte (1GB)

1024 GB = 1 Tera Byte (1TB)

Мэдээлэл боловсруулах хурд:

- Компьютерийн хурдыг нь MHz нэгжээр хэмжинэ. 1MHz хурд нь 1секундээд 1сая цикл хийгдэнэ гэсэн уг. Сүүлийн үеэг компьютерийн мэдээлэл боловсруулах хурд их нэмэгдэж байгаа. 1024MHz = 1GHz тэнцэнэ.

Бусад хэмжих нэгж:


- Дээрх багтаамж, хурд хэмждэг хоёр нэгжээс гадна маш олон хэмжих нэгж байдаг. Жишээ нь hard дискний хувьд эргэлтийн хурд байх бөгөөд RPM - Revolutions Per Minuite нэгжээр хэмжинэ. Нягтралыг DPI - Dot Per Inch нэгжээр хэмжинэ. 1 секунд хэдэн bit мэдээлэл дамжуулахыг Bps - bits per second нэгжээр хэмжинэ. Гэх мэтээр олон нэгжээр хэмжилт хийнэ.



BIOS –Үндсэн Оролт Гаралтын Систем

Энэ нь basic input/output system буюу орчуулбал оролт гаралтын үндсэн систем гэсэн утгатай. BIOS нь микросхем дээр тусгайлсан бичсэн программ бөгөөд компьютерийг асаахад эхлээд BIOS ачаалдаг. Түүнчлэн компьютер дэх үйлдлийн систем болон компьютерт холбогддог дагалдах төхөөрөмжүүдийн хатуу диск, видео адаптер, гар, хулана болон принтер) хоорондох өгөгдлийн дамжуулалтыг зохицуулдаг байна.

Энэхүү BIOS ROM нь chip хэлбэртэй motherboard дээр суурىлагддаг ба ихэвчлэн Award, Phoenix нувчилд үйлдвэрлэнэ.



BIOS-ын биелүүлдэг олон функциудын нэг бол системийг ачаалахад гүйцэтгэх түүний нүрэг юм. Компьютерийг асаахад системийн үндсэн санах ой хөсөн байх бөгөөд нэн түрүүнд бүх дагалдах төхөөрөмжүүдийг шалгааг дараа нь үйлдлийн системийг хатуу диск эсвэл бусад дискний төхөөрөмжөөс дуудан уншиж, motherboard дээр суурىлагдсан тогтолцоог санах ойд ачаалдаг. Дагалдах төхөөрөмжүүдийн хаяглагтыг өөрчлөх нэхцэлд үүнийг BIOS л зөвхөн гүйцэтгэж чадахас бус үйлдлийн систем болон хэрэглээний програмуудын эль нь чухал боломжгүй.




BIOS ажиллаж эхэлмэгцээ хамгийн түрүүнд эхний шалгах хэсгийнүүлдлийг хийж эхлэх ба нийнүүг POST (Power-On Self-Test) гэнэ. Хэрэв таны компьютерийн аль нэг дагалдаа төхөөрөмж, элемент гэмтэлтэй байвал энэ нь уг тестийн явцад илрч дэлгэц дээр мэдээлэгдэнэ.

CMOS нь BIOS дотор байрлах санах ой юм. Энэ санах ой нь 3.5V тэжээлээр тэжээгдэж байдаг. BIOS нь тохиргоог CMOS Setup /Complementary Metal Oxide Semiconductor Setup/ програмын тусламжтай хийнэ. Энэхүү тохиргоо нь шууд техник хангамжтай харьцаж байгаа тул зааварын дагуу хийхгүй бол аюултайг анхаар.

BIOS-ын мэдээлэл

BIOS ажиллаж эхлэх чадвартай түүний мэдээллийг харах болно. Тухайн компьютерийн BIOS нь ямар хувилбартай альүүлдвэр компаниуд хэдэн онд үүлдвэрлэсэн, ямар serial дугаартай зэргийг харна.





Системийн тухай мэдээлэл

BIOS дискинээсүүлдлийн системийг ачаалахын өмнө таны компьютерийн системийн бүтцийн тухай товч мэдээлэл өгдөг. Өөрөөр хэлбэл таны компьютерийн хүчин чадлыг шалгана гэсэн уг. Үүнд:

- ⦿ BIOS -ын үйлдвэрлэсэн компани нэр, он сар өдөр зэрэг мэдээлэл Жишээ нь: Award Software 1984 - 2009
- ⦿ Motherboard буюу эх хавтаны мэдээлэл. Жишээ нь: P55-UD6 F5d энэ нь intel i7 CPU таарах эх хавтан
- ⦿ Процессорын (CPU) төрөл, хурд, нэр зэргийн мэдээлэл. Жишээ нь: Intel (R) Core(TM) i7 CPU 2.80Ghz
- ⦿ Санах ой (RAM) төрөл, хурд, нэр зэргийн мэдээлэл Жишээ нь: 4190208KB энэ нь 4GB юм.
- ⦿ IDE/ATA Drives: Энэ нь компьютерт сууршлагдсан primary master, primary slave эсвэл secondary master, secondary slave дискний тухай мэдээлэл байх ба өөрөөр хэлбэл энэ хэсэг таны компьютерийн хатуу дискний хэмжээ, төрлийг харуулна.
- ⦿ Floppy drive A: Танигдсан A дискний хэмжээ, багтаамж
- ⦿ Floppy drive B: Танигдсан B дискний хэмжээ, багтаамж
- ⦿ Display -ний төрөл: VGA/SVGA гэх мэтээр бичигдэх ба энэ нь дэлгэцний талаарх хамгийн ерөнхий мэдээлэл
- ⦿ Serial ports: Энэ бол таны компьютерийн оролт ба гаралтын serial (I/O COM) портын хаягийн тухай мэдээлэл юм. Хэвиийн сонголтоор бол энэ нь 3F8h, 2F8h гэсэн утга авдаг.
- ⦿ Parallel ports: Таны компьютерийн оролт ба гаралтын параллель (I/O LPT) портын хаягийн тухай мэдээлэл

Мөн CMOS Setup програм руу орох товчлуурын нэрийг (ихэвчлэн Del, Ctrl+Alt+Esc, F2) харуулна.



CMOS - Complementary Metal Oxide Semiconductor

Мэдээллийг шалгаж дэлгэцэн гаргахын тулд BIOS ут компьютерийг анх ажилд бэлэн болгох үеig бүх мэдээллээ өөрийн CMOS (Complementary Metal Oxide Semiconductor) ойдоо хадгалсан байдаг. Энэ бол BIOS дотор ихэвчлэн 64К зай эзэлж байдаг логик ой юм. Харин хадгалагсан мэдээллээ алдахгүй байхын тулд BIOS-ын микросхемийг 3.5V-ийн батарейгаар тэжээж байдаг ба энэ нь мөн motherboard дээр байрладаг байна.



CMOS SETUP Utility:

Техник хангамж, тоног төхөөрөмжүүд хоорондын тохиргоог хийх, тэдгээрийг ажиллуулах эсэх зэргийг **SETUP** програмын тусламжтай гүйцэтгэнэ. Мөн компьютерт хамгаалалт тавьж болдог. Setup дотор хийсэн тохиргоо нь техник тоног төхөөрөмжүүд болон систем эхлэх үеийн ажиллагаа учир маш хянамгай зааврын дагуу зөв гүйцэтгэх

Заавар нь motherboard-г дагалдан ирдэг ном дээр дэлгэрэнгүй байдаг. Буруу тохиргоо хийсэн тохиолдолд тоног төхөөрөмж эвдрэх, эсвэл ажиллахгүй болох, систем алдаа өгөх зэрэг аюултай зүйлүүд бий болно.

Ер нь CMOS дотор хадгалагдах мэдээллийг сайн хамгаалах хэрэгтэй. Ихэнх хэрэглэгч password буюу нууц кодоор хамгаалдаг. CMOS Setup тохиргооруу ороход нууц үт асуудагаар тохируулах хэрэгтэй. Энэхүү нууц үгийг мэдэхгүй бол CMOS дотор орж улмаар тохиргоог өөрчилэх боломжгүй болно. Мөн компьютерийг энэхүү нууц үгний тусламжаар хамгаалах боломжтой.

Press to enter BIOS setup



CMOS SETUP тохируулгийн програм дээрх хоёр хэлбэртэй.
Гэхдээ дотор байгаа тохиргоо нь ижил төстэй.



CMOS SETUP програмын доторх функцуудыг ашиглан тохиргоо хийхийн өмнө дараах нэр томъёог сайн мэдэх хэрэгтэй.

Open, On, Enable - нээлттэй гэсэн ерөнхий нэг утга

Close, Off, Disable - хаалттай гэсэн ерөнхий нэг утга

Defaults — тогтмол хэвшмэл утга

Мөн гарны товчлуур ашиглан тохиргоо хийдэг учир тогтмол ашиглагдах гарны товчлуурын нүргийг сайн мэдэх.

Товчлуур:

Enter

Esc

Up arrow

Down arrow

Left arrow

Right arrow

Page Up

Page Up

+ Key

- Key

F1 Key

F5 Key

F6 Key

F7 Key

F10 Key

Esc Key

Гүйцэтгэх нүрэг:

Гүйцэтгэх команд

Үгүйсгэх буцаах команд

Сонголтыг дээш зөөх

Сонголтыг доош зөөх

Сонголтыг энн тийш зөөх

Сонголтыг баруун тийш зөөх

Өөрчлөлтийг нэмэх

Өөрчлөлтийг хасах

Өөрчлөлтийг нэмэх

Өөрчлөлтийг хасах

Заавар тусламж авах

Хэвшмэл тохиргоог сэргээх

Аюултай өөрчлөлтийг хэвшмэл

тохиргоогоор сэргээх

Бүх өөрчлөлтийг хэвшмэл

тохиргоогоор сэргээх


CMOS доторх бүх өөрчлөлтийг

хадгалан гарах

Олон давтан дарсанаар CMOS

доторх бүх өөрчлөлтийг

хадгалахгүй гарах



CMOS SETUP тохиргооны цонх бөгөөд эдгээрээс өргөн хэрэглэдэг зарим нэг функцуудыг авч үзье.

Standard CMOS Features

Системийн он, сар, өдөр, цаг, минутын тохиргоо мөн диск төхөөрөмжүүдийн төрөл зэргийг сонгох. Мөн аль нэг дискийг түр зуур ажиллуулахгүй болох зэрэгт хэрэглэнэ.

Date - Системийн он сар өдрийн тохиргоо

Time - Системийн цагийн тохиргоо

IDE 0 Master - Хатуу дискний төрөл хэмжээ

IDE 0 Slave - CD, Хатуу диск төрөл хэмжээ

IDE 1 Master - CD, Хатуу диск төрөл хэмжээ

IDE 1 Slave - CD, Хатуу диск төрөл хэмжээ

IDE 2 Master - CD, Хатуу диск төрөл хэмжээ

IDE 2 Slave - CD, Хатуу диск төрөл хэмжээ

IDE 4 Master - CD, Хатуу диск төрөл хэмжээ

IDE 4 Slave - CD, Хатуу диск төрөл хэмжээ

Drive A - Уян дискний төрөл хэмжээ

Halt On - Аялаа шалгарах мэдээлэх



Standard CMOS Features	
Date (mm:dd:yy)	Tue, Mar 2 2010
Time (hh:mm:ss)	12 : 56 : 14
► IDE Channel 0 Master	[CORSAIR CMFSSD-64CBC]
► IDE Channel 0 Slave	[None]
► IDE Channel 1 Master	[ASUS DUD-E616A3T]
► IDE Channel 1 Slave	[None]
► IDE Channel 2 Master	[None]
► IDE Channel 2 Slave	[None]
► IDE Channel 4 Master	[None]
► IDE Channel 4 Slave	[None]
► IDE Channel 5 Master	[None]
► IDE Channel 5 Slave	[None]
Drive A	[None]
Floppy 3 Mode Support	[Disabled]

Advanced CMOS Features

Вирусны хамгаалалт, систем ямар дискнээс эхлэн унших, BIOS болон системийн хамгаалалт хийх зэрэгт хэрэглэнэ. Мөн ямар нэг техник хангамжийн хаяглалтыг өөрчлөх, түр ажиллуулахгүй байх зэрэг тохиргоонууд хийгдэнэ.

Virus Warning - Вирусны хамгалалт

First Boot Device - Систем 1-р унших диск төхөөрөмж

Second Boot Device - 2-р унших диск төхөөрөмж

Third Boot Device - 3-р унших диск төхөөрөмж

Security Option - Хамгаалтын түвшин

system бол компьютерийг бүхэл нь хамгалах

setup бол зөвхөн CMOS тохиргоог хамгаалах

Тайлбар: Систем суулгах тохиолдолг First Boot Device тохиргоог Bootable диск юун дээр байгаагаас хамааран тохируулна. Bootable диск голдуу CD дээр байдаг. Систем суусаны дараа HDD-01 гэсэн тохиргоо хийнэ.



Advanced Chipset Features ба Integrated Peripherals

Энэ функц нь бүх микросхем буюу чипчудийн /chipset/ холбоотой тохиргоо хийнэ. Эдгээр хэсгийн тохиргоогүйлдвэрээс тогтмол /Defaults/ утгаар тохируулсан байдаг учир нэг их өөрчилөхгүй.

Power Management Setup

Компьютерийн тэжээлийн хэсэг болон нэмэлт төхөөрөмж тэдгээрийн тохиргоо. Энэ хэсгийн тохиргоогүйлдвэрээс тогтмол /Defaults/ утгаар тохируулсан байдаг учир нэг их өөрчилөхгүй.

PNP/PCI Configuration

Төхөөрөмжийн холболт, суурь, хаяглалт зэргийн тохиргоо. Энэ хэсгийн тохиргоогүйлдвэрээс тогтмол /Defaults/ утгаар тохируулсан байдаг учир нэг их өөрчилөхгүй.

PC Health Status

Компьютерийн аюулгүй ажиллагааг хангах тохиргоо түүний мэдээлэх хэсэг. Энэ хэсгийн тохиргоогүйлдвэрээс тогтмол /Defaults/ утгаар тохируулсан байдаг учир нэг их өөрчилөхгүй.

Frequency/Voltage Control

Хүчдэл, вольт, давтамж зэргийн тохиргоо. Энэ хэсгийн тохиргоогүйлдвэрээс тогтмол /Defaults/ утгаар тохируулсан байдаг учир нэг их өөрчилөхгүй.

Анхааруулга:

Эдгээр хэсгийн тохиргоог тэр болгон өөрчилөх шаардлагагүй. Хэрэв өөрчилөх шаардлагатай бол Motherboard-ийн дагалдаж цурсэн ном, хэлхээний болон микросхемийн хүчин чадал, үзүүлэлтийг сайтар судалсаны үндсэн дээр гүйцэтгэнэ. Ер нь эдгээр тохиргоо нь тухайн motherboard-ийн тохирууланүйлдвэрээс тогтмол /Defaults/ утгаар тохируулсан байдаг.



Load Fail-Safe Defaults

Load Optimized Defaults

CMOS SETUP програмын анхны үндсэн тохиргоог сэргээхэд хэрэглэнэ. Энэ нь маш хэрэгтэй функц. Хэрэглэгч SETUP дотор байгаа функцуудын авах утгуудыг санаатай болон санамсаргүй өөрчилж өгдөг. Эдгээр өөрчлөлт нь тоног төхөөрөмжүүдтэй зохицохгүй буюу аюултай байж болно. Тиймээс дээрх функцийн анхны үндсэн тохиргоог сэргээдэг.

Load Fail-Safe Defaults - Аюултай өөрчлөлтийг анхны үйлдвэрийн хэвшмэл тохиргоогоор сэргээх

Load Optimized Defaults - Бүх өөрчлөлтийг анхны үйлдвэрийн хэвшмэл тохиргоогоор сэргээх

CMOS Setup Utility – Copyright (C) 1984-2006 Award Software

Standard CMOS Features	Frequency/Voltage Control
Advanced BIOS Features	Load Fail-Safe Defaults
Advanced Chipset Features	Load Optimized Defaults
Integrated Peripherals	Set Supervisor Password
Power Manag.	Load Optimized Defaults (Y/N) ? Y
PNP/PCI Configuration	Save & Exit Setup
PC Health Status	Exit Without Saving
Esc : Quit F9 : Menu BIOS	←→↑↓ : Select Item
F10 : Save & Exit Setup	
Time , Date , Hard Disk Type ...	

Анхааруулга: Та санаатай болон санамсаргүй өөрчлөлт хийсэн тохиолдол дээрх анхны тогтмол утгаар CMOS мэдээллийг сэргээх хэрэгтэй.



Set Supervisor Password

Set User Password

Энэ функцууд нь BIOS болон системд хамгаалалт хийхэд хэрэглэнэ. Өөрөөр хэлбэл таны компьютер нууц үгийн тусламжтай тохиргоо хийгдэх, систем эхлэх зэрэг хамгаалалттай болно. Нууц үгээ аль болох мартахааргүй уг сонгох нь чухал. Энэ функцийг ашиглан нууц үгээ оруулна. Мөн устгаж, өөрчилж болдог. Нууц үгээ оруулаад дараа нь Advanced CMOS Features дотор нууц үг ямар түвшинд ажиллахыг сонгоно.

system бол компьютерийг бүхэл нь хамгалах

setup бол зөвхөн CMOS тохиргоог хамгаалах гэсэн хоёр түвшин байдаг. Таны өөрийн ашигласан нууц үгийн тусламжтай таны компьютер ажиллана. Тиймээс энэхүү нууц үгээ мартаж болохгүйг анхаар.

CMOS Setup Utility – Copyright (C) 1984-2006 Award Software

Standard CMOS Features	Frequency/Voltage Control
Advanced BIOS Features	Load Fail-Safe Defaults
Advanced Chipset Features	Load Optimized Defaults
Integrated F	Enter Password : <input type="text"/> password
Power Management Setup	Set User Password
PNP/PCI Configuration	Save & Exit Setup
PC Health Status	Exit Without Saving
Esc : Quit F9 : Menu BIOS	←→↑↓ : Select Item
F10 : Save & Exit Setup	
	Time , Date , Hard Disk Type ...

Set Supervisor Password - Давуу эрхтэй хэрэглэгч

Set User Password - Энгийн хэрэглэгч



- Давуу эрхтэй хэрэглэгч нь бүх тохиргоог хийх боломжтой.
- Энгийн хэрэглэгч нь давуу эрхтэй хэрэглэгчийн хийн тохиргоог хийх боломжгүй бөгөөд зөвхөн харах л үүрэгтэй.

Password буюу нууц үгээ устгах

Устгахын тулд Set Supervisor Password, Set User Password функцуудыг ажиллуулах ба шинэ нууц үг бич гэсэн цонх гарах ба уг цонх дээр ямар нэг үг бичихгүйгээр Enter товч дарна. Улмаар дараах цонх нээгдэж нууц үг устгагдана.

Password буюу нууц үг өөрчилэх

Хуучин нууц үг өөрчилөх шинэ нууц үг тавих нь ижил бөгөөд Set Supervisor Password, Set User Password функцуудыг ажиллуулах ба шинэ нууц үг бич гэсэн цонх гарах ба уг цонх дээр шинэ нууц үгээ бичихээд Enter товч дарна. Улмаар баталгаажуулах цонх гарч ирэх ба мөн нууц үгээ давтан бичиж баталгаажуулна.

CMOS Setup Utility – Copyright (C) 1984-2006 Award Software

Standard CMOS Features	Frequency/Voltage Control
Advanced BIOS Features	Load Fail-Safe Defaults
Advanced Chipset Features	Load Optimized Defaults
Integrated Peripherals	Set Supervisor Password
Power Management	Press any key to continue
PNP/PCI Configuration	Save & Exit Setup
PC Health Status	Exit Without Saving
Esc : Quit F9 : Menu BIOS	←→↑↓ : Select Item
F10 : Save & Exit Setup	
	Time , Date , Hard Disk Type ...



Save & Exit Setup

Энэ функц нь таны хийсэн тохиргоог хадгалаж гарахад хэрэглэнэ. Энэ улдлийг F10 товчлуураар гүйцэтгэж болно. Save & Exit Setup командаа өгсөнөөр дараах цонх гарах ба Y / yes/ товч дарж командыг биелүүлнэ. Харин N /no/ товчлуур дарвал командаа хүчингүй болно.

CMOS Setup Utility – Copyright (C) 1984-2006 Award Software

Standard CMOS Features	Frequency/Voltage Control
Advanced BIOS Features	Load Fail-Safe Defaults
Advanced Chipset Features	Load Optimized Defaults
Integrated Peripherals	Save & Exit Setup (Y/N) ? Y
Power Management Setup	Password
PNP/PCI Configuration	Set User Password
PC Health Status	Save & Exit Setup
	Exit Without Saving
Esc : Quit F9 : Menu BIOS	←→↑↓ : Select Item
F10 : Save & Exit Setup	
	Time , Date , Hard Disk Type ...

Exit Without Saving

Энэ функц нь CMOS дотор хийсэн өөрчилэлтийг хадгалахгүй гарахад хэрэглэнэ.

CMOS Setup Utility – Copyright (C) 1984-2006 Award Software


Standard CMOS Features	Frequency/Voltage Control
Advanced BIOS Features	Load Fail-Safe Defaults
Advanced Chipset Features	Load Optimized Defaults
Integrated Peripherals	Exit Without Saving (Y/N) ? Y
Power Management Setup	Set User Password



MB Intelligent Tweaker (M.I.T.)

Энэ нь сүүлийн чуийн i3, i5, i7 зэрэг CPU суурилах эх хавтангийн хувьд ашиглагдах шинэ функц юм. Бид өмнө нь CPU, RAM, Motherboard зэргийн хоорондийн тохиргоог Jumper ашиглаж хийж байсан бол энэ функцийн тусламжаар шууд хийх боломжтой болсон. Гэхдээ нэг зүйл хэлтэхэд тухайн эх хавтан нь чадвэрээс стандарт тохиргоо хийгдсэн байдаг учир энд тэр болгон өөрчлөх шаардлагагүй.

Энд мэргэжилүүдийн түвшиний нэлээд тохиргоог хийх боломжтой. Тиймээс эх хавтанг дагалдан ирсэн номыг ашиглах хэрэгтэйг анхаарна уу.



POST алдааны мэдээлэл

Бид BIOS оёрийн тоног төхөөрөмжөө шалгадаг талаар үзсэн. Энэ нь автоматаар хийгдэх бөгөөд алдаа байхгүй бол шууд л цааш систем ачааллах боломж олгоно. Харин алдаатай байвал текст юмуу дуут дохиогоор мэдээлэл өгнө энэ талаар хойно авч үзнэ.



Компьютерийн програм хангамж

Компьютерийг хоёр салбарт хуваагдана гэж дээр нээсэн. Програм хангамж гэдэг нь техник хангамжийг хэрэглэгч бүрэн хэрэглэх нөхцөлийг хангаж өгдөг байх ёстой. Тиймээс хувьсийн мэддэг хэл дээр бичигдсэн командуудын дараалал юм. Дэлхий дээрх компьютерийн програм хангамжийн ихэнх хувь нь Англи хэл дээр ба том улс гурниудийн хэл дээр бичигдсэн байдаг. Гэхдээ тухайн улс орон өөрийн хэл дээрээ програмаа зохион хэрэглэх нь нэлээд элбэг байна. Програм хангамжийг - системийн /Үйлдлийн систем/ - хэрэглээний /Word, Excel.../ - driver install /техник хангамжийг ажиллуулах/ - мэргэжлийн /AutoCAD, MahtCAD/ - utility програм /NortonAntiVirus, Scandisk, PartitionMagic.../ гэх мэт ангилж болно.

Үйлдлийн систем - Operating system


Техник хангамж болон програм хангамжийн хоорондын үйл ажиллагааг зохицуулан хэрэглэгчдэд хамгийн энгийн хэлбэрээр компьютертай харьцах боломж өгч байгаа системийн програм юм.

Дэлхий дээр Windows, Unix, Linux гэх мэт үйлдлийн системүүд хэрэглэгдэж байна. Эдгээрээс хамгийн өргөн хэрэглэдэг нь Windows үйлдлийн систем юм. Одоогоор манааг WindowsXP, Windows7 үйлдлийн системүүдийг өргөн хэрэглэж байна. Ер нь Microsoft -ийн үйлдлийн систем нь MS-DOS, нэртэйгээр анх гарч байсан бол Windows3.11, Windows95, Windwos98, WindowsMe, Windows2000, WindowsXP, WindowsVista, Windows7 зэрэг хувилбаруудаар өнөөг хүртэл үйлдвэрлэгдэн шинэчилэгдэж байгаа.



Албан ёсоор бүрэн хувилбараар гарсанүйлдлийн систем бол Windows 95 plus, Windows 98 second edition хувилбар гэж нэдэг. Windows XP нийлдлийн системийн хувьд олон дахин шинэчилэгдэж Service Pack-1, Service Pack-2 нэртэй бүхий хувилбарууд гарсан. Эдгээр нийлдлийн систем нь хэрэглэхэд маш бага алдаа гардаг.

Үнээс гадна Windows NT технологитой нийлдлийн системийг сүлжээ болон компьютер серверт хэрэглэж байна. Энэ нь энгийн хэрэглээнд хэрэглэхэд тохиromжтүү.





Хэрэглээний програм хангамж

Хүмүүсийн харьцааны хэл дээр хийгдсэн ямар нэг мэдээлэл боловсруулахад зориулагдсан програмуудыг хэлнэ. Иймээс хэрэглээний програм гэдэг нь хүмүүс компьютерийг ашиглахад хялбар болгож өгсөн. Жны: зураг зурах, хүснэгт байгуулж тооцоо хийх, дуу сонгох, тоглох зэрэг. Програм хангамж нь файлуудаас бүрдэнэ.

File - Файл

Файл гэдэг нь мэдээллийг хадгалах үндсэн хэлбэр юм. Өөрөөр хэлбэл тодорхой нэртэй, тодорхой бүтэцтэй дискэн дээр хадгалахад булэг мэдээлэл. Файл болгонөөрийн нэртэй, ямар программ дээр хийгдсэн файл гэдгээсээ хамааран өөр өөрийн гэсэн оргөтгөлтэй байх бөгөөд энэ өргөтгөл нь З тэмдэгт байна. Тэр өргөтгөлөөр нь тухайн файлыг ямар төрлийн файл гэгдүүг нь ялгаж ангилна. Файлын төрлүүд


Системийн -exe, dll, ini, sys, com, vxd, inf

Баримт бичиг -doc, txt, xls, pmd

Зураг -jpg, bmp, gif, psd, tif

Дуу, видео -mp3, wav, avi, mpeg, mov

Файлын хэмжээг бидний өмнө үзсэн мэдээлэл хэмжих нэгжээр хэмжинэ. Жны: 21кв, 245мв, 8в гэх мэт





Folder - Фолдер

Файлуудыг эмхлэх, төрөлжүүлэх нүүднээс нүүссэн хавтсыг фолдер гэнэ. Зарим ном сурх бичигт директор, ~~сан~~, каталог гэж нэрлэх тохиолдол гардаг. Дээрхийн ажил фолдер нь мөн нэйтэй байна. Файл, фолдерийн жишээ гэвэл амьдралд маш олон байдаг. Бид нэг хичээлийн дэвтрэйг файл гэвэл хичээлүүдийг төрөлжүүлэн нэг нэг шүүгээнд хийж тэрхүү шүүгээнүүдээ нэр өгвөл энэ нь фолдер болно. Фолдер дотор хэдэн ч дэд фолдер байж болдог.

Та компьютер дээрх мэдээллээ төрөлжүүлэх folder нүүгэж хадгалах нь тэдгээр мэдээллийг хэрэглэхэд маш хялбар болгодог. Жинь: Дууны файлуудыг хамтлаг дуучид, цомог, улс түрнээр нь төрөлжүүлэх хэрэгтэй.

- My Computer
- system XP (C:)
 - Documents and Settings
 - Fonts
 - games
 - Program Files
 - Adobe
 - Alawar
 - Aleo Software
 - Flash Intro and Banner Maker
 - Bonjour
 - Canon
 - Common Files
 - Adobe
 - Acrobat
 - Adobe Anchor Service
 - Adobe Anchor Service CS4.m.070
 - Adobe Asset Services CS3
 - Adobe Creative Suite 3 Design Premium
 - Adobe Creative Suite 4 Master Collection
 - Adobe PCD
 - Adobe Photoshop CS4
 - Adobe Version Cue CS3
 - Adobe Version Cue CS4
 - AMT
 - AMT20
 - backup



Utility програм

Техник хангамжийг ямар нэг хэлбэрээр дэмжих, түүнийг засах, шалгах зэрэгт хэрэглэгдэнэ. Энэ төрлийн программ хангамж нь компьютерийн гэмтэл засварт хэрэглэгдэнэ. Жишээ болгож зарим нэг програмыг узье.

Scandisk: Диск төхөөрөмжийн гадаргууг шалгах түүнийг засварлахад хэрэглэнэ. Компьютер буруу унтраасан тохиолдолд энэ нь автоматаар ажилладаг програм юм.

Back Up and Restore: Энэхүү програм нь компьютерийн үйлслийн систем болон тодорхой нэг файлыг архивлан хадгалахад зориулагдсан. Жишээ нь: Үйлслийн систем бүрэн төгс ажиллаж байхад нь Back up хийчихээд дараа ямар нэг догоил гол гарах veg Restore буюу сэргээх үйлдэл хийдэг.

DirectX: Энэхүү програм нь техник хангамжийн хувчин чадлыг нэмэгдүүлэх, шалгах үүрэгтэйгээс гадна техник хангамжийн ажиллагааг зөв хуваарлан өгдөг. Ялангуяа AGP картны видео дурслэлийг, дууны гаралтыг сайжруулна.

NortonAntiVirus: Компьютерийг вируснаас хамгаалах, вирус цэвэрлэх, устгах үүрэгтэй. Энэхүү програм нь таны компьютерт зайлшгүй байх ёстой программын нэг.

NortonUtility: Компьютерийг техник хангамж, програм хангамжийн ажиллагааг шалгах, тэдгээрийг засварлах, хяналт тавих зэрэгт хэрэглэнэ.

PartitionMagic: Hard disk төхөөрөмжийг ажилд бэлтгэхэд хэрэглэнэ. Өөрөөр хэлбэл hard дискэнд partition тавих, устгах, өөрчлөх, форматлах зэрэгт хэрэглэнэ.



Driver /драйвер/ програм

Энэ нь үйлслийн систем болон техник хангамжийн хоорондын тохиргоо хийхэд хэрэглэнэ. Өөрөөр хэлбэл техник хангамжийг ажиллуулахад зориулсан програм. Энэ програм нь тухайн тоног төхөөрөмжийг дагалдан црэх бөгөөд ямар үйлслийн систем тус бурт зориулагдсан байдаг. Мөн тоног төхөөрөмжийг дагалдан заавар агуулсан ном ирнэ. Энэ ном дээр тухайн төхөөрөмжийн талаар дэлгэрэнгүй бичсэн байдаг.



Үйлслийн системд hardware буюу техник хангамжийг хэрхэн таниулан ажиллуулах талаар дараа дэлгэрэнгүй авч үзнэ. Тиймээс энд товч бичлээ.

Мэргэжлийн програм

Хэрэглээ програмтай адил бөгөөд зориулалт нь тодорхой нэг зүйл зориулагдсан. Жишээ нь: барилга, техникийн зураг зурах AutoCAD, SolidWorks, 3D MAX хэвлэлийн эх бэлтгэх график дизайны Adobe Photoshop, PageMaker, Corel-DRAW, химиин шинжилгээ хийх гэх мэт. Мөн програм зохиоход зориулагдсан JAVA, PHP, ASP, JavaScript, HTML, Delphi, Pascal, VB, C, C+ гэх мэт програмчилалын хэлний програмууд байдаг.



Hard Disk - Ажилд бэлтгэх

Bug hard diskний талаар өмнө үзсэн. Компьютерт заавал нэг хатуу диск байх ба тэр хатуу диск дээрүүллийн систем суудаг. Тиймээс хатуу дискийг хэрхэн ажилд бэлтгэх талаар авч үзье. Үүлдвэрээс ирсэн хатуу дискийг дараах байдлаар ажилд бэлдэж хэрэглэнэ.

- Partition үүсгэх
- Format - форматлан цэвэрлэх
- Үүлдлийн систем суулгах

Хатуу дискийг дагалдах диск болгож хэрэглэхээр бол Partition үүсгээд, форматлаад л шууд хэрэглэнэ. Дээрх үүлдлийг Bootable дискний тусламжтай гүйцэтгэнэ. Мөн үүлдлийн систем суулгахаар бол тухайн үүлдлийн системийн Install disk хэрэгтэй.

Bootable - Системтэй диск

Энэ диск нь үүлдлийн системийн жижигрүүлэсэн хувилбарыг агуулсан /MS-DOS/ бөгөөд компьютерийг MS-DOS орчинд эхлиүүлэх үүрэгтэй. Bootable дискийг StartUp диск, bootdisk гэх мэтээр нэрлэдэг.

Win95, Win98, WinMe - FAT32

WinNT, WinXp, WInVista, Win7 - NTFS, FAT32

төрлийн DOS partition дээр суудаг. Тиймээс bootable диск нь дээрх хоёр төрлийн байдаг. Өөрөөр хэлбэл Win95, Win98, WinMe зэрэг нь нэг төрлийн bootable диск хэрэглэдэг гэсэн уг. Гэхдээ үүлдлийн систем болгон bootable дисктэй.

Bootable диск бэлтгэх

Энэхүү дискийг голгүү Floppy диск, Flash дээр бэлдэж авдаг. Сүүлийн veg CD driver их хэрэглэдэг болсон болохоор CD дээр bootable диск бэлтгэн өргөн хэрэглэж байна. WindowsXP, WindowsVista, Windows7 үүлдлийн системийн хувьд install диск нь bootable дисктэйгээ хамт байдаг болсон.



WindowsXP, WindowsVISTA, Windows7 зэрэг үйлдлийн систем суулгах

Эдгээр Windows үйлдлийн системүүдийг компьютерт суулгах үйлдэл нь бараг төстэй байдаг учир Windows7 үйлдлийн системийн шинээр компьютерт суулгах талаар авч үзье. Бидэнд Windows7 үйлдлийн системийг install disk, bootable disk хэрэгтэй. Энэ нь DVD дээр бичигдсэн байдал.

Анхаарах зүйл: Бид шинээр суулгах талаар авч үзэж байгаа. Харин өмнө нь ямар нэг үйлдлийн систем хэрэглэж байгаа компьютерт бол та өөрийн хэрэгтэй файл, фолдерийг flash, CD эсвэл өөр хатуу диск дээр хуулсан байх шаардлагатай. Мэдээж хэрэгтэй файл, фолдер байхгүй бол дараах ажиллагааг шууд эхлэж болно.

Мөн бид хатуу дискээ c: d: e: f: гэх мэтээр хэдэн хэсэг болгон хувааж ашигладаг. Үйлдлийн систем гол төлөв c: диск дээр суусан байдаг тул үйлдлийн систем суугаагүй d: e: f: зэрэг диск дээр байгаа файл фолдер яг хэвээр хадгалагдах болно. Тиймээс c: диск дээр байгаа хэрэгтэй зүйлээ бусад диск дээр хуулаж авах хэрэгтэй. Ингэсэнээр таны хэрэгтэй зүйл үйлдлийн систем суугаагүй диск дээр хуулагдана гэсэн уг. Үүний дараа та дараах үйлдлийг хийж байх явцад анхааралтай хандахыг сануулъя. Өөрөөр хэлбэл d: e: f: зэрэг дискний partition -ийг устгах, форматлах зэрэг үйлдэл хийж болохгүй. Зөвхөн c: дискний хувьд л үйлдлийг хийж болно.



Үйлдлийн систем гэмтсэн бөгөөд c: диск дээр байгаа хэрэгтэй зүйлээ авч чадахгүй тохиолдолд өөр portable үйлдлийн систем /flash юмуу CD дээр байдаг/ хэрэглэх эсвэл хатуу дискээ өөр компьютерт холбож хэрэгтэй зүйлээ хуулж авч болно. Харин c: диск хэрэгтэй зүйл байхад нь үйлдлийн систем дарааг суулгавал таны хэрэгтэй зүйл устгагдана.



Нэгдүгээр алхам:

Компьютераа асаагааг DVD driver дотороо Windows 7 вүлдлийн системийн install CD хийнэ. Улмаар CMOS Setup дотор орж Advanced CMOS Features доторх First Boot Device функцыг утгийг CDROM болгож өөрчилээд өөрчлөлтөө хадгалан гарна. Энэ вүлдлийг дээр BIOS -ийн тайлбар хэсэгт хэлсэн байгаа.


Харин таны компьютерийн BIOS -ийн төрөл өөр бол тухайн тохиргоо арай өөр хийгдэнэ. Өөр нэг тохиолдол нь CMOS Setup дотор орж Boot доторх 1st Boot Device функцыг утгийг CDROM болгож өөрчилээд өөрчлөлтөө хадгалан гарна.



Дээрх зургаар 2 тохиолдолыг үзүүллээ. Ер нь BIOS -ийн төрөл өөр боловч уг хэллэг ашиг байдаг болохоор хэцүү биш байх.



Мөн сүүлийн чийн BIOS нь заавал дотор нь орж тохиргоо хийхгүйгээр компьютер асах явцад F11, F12 зэрэг функциялт товч ашиглан Boot Menu командыг дараах байдлаар гаргаж болно. Эндээс та гарын товчлуурын тусламжтай CD-ROM Drive командыг өгөхөд шууд бидний DVD дээр байгаа Windows7 вүлдлийн системийн bootable диск унших болно.





Хоёрдугаар алхам:

BIOS доторх тохиргоо юмуу Boot Menu ашиглаж CD ээс boot уншуулахад дараах мэдээлэл гарах бөгөөд та ямар нэг товч гарсанаар цааш үргэлжилинэ.


**Press any key to boot from CD or DVD...
...**

